

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН 2025-2028 ОНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /202.. он/	Зорилтот түвшин /2025 он/	Санхүүг ийн эх үүсвэр	Хэрэгжилт	Хувь
Ерөнхий чиг үүрэг: Хүн ам, гэр бүлийг дэмжих							
Үндсэн чиг үүрэг: Хүн ам, гэр бүлийн хөгжлийн бодлого							
Зорилт 1: Гэр бүлийг дэмжих, гэр бүлд ээлтэй хөгжил хамгааллын тогтолцоог бэхжүүлэх	1.1.Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх	Өргөн мэдүүлсэн хуулийн төсөл	-	1	-	Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр хэлэлцүүлж, УИХ-д өргөн барихаар тогтсон. Шинэ Засгийн газар байгуулагдсантай холбогдуулан хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг дахин батлуулах шаардлага үүссэний дагуу 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/2619 тоот албан бичгээр Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг ХЗДХСайдтай хамтран батлахаар хүргүүлж, 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр үзэл баримтлалын төслийг албажуулан ХЗДХЯ-нд хүргүүлсэн. 2025 оны 11 дүгээр сард ХЗДХ-ийн сайд өөрчлөгдсөнтэй холбогдуулан ГБХДТХ-ийн үзэл баримтлалыг ХЗДХ-ын сайдтай 3 дахь удаагаа хамтран батлуулах бичгийг ГБХНХ-ын сайдын 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/3877 тоот бичгээр илгээж, 12 дугаар сарын 09-ний өдөр баталсан. Хуулиар эрх ашиг нь хөндөгдөх бүлгүүд, иргэдийн төлөөлөл, төр, төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачдын төлөөллөөр хэлэлцүүлсэн 13 хэлэлцүүлгийн тайлан гаргасан. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл боловсруулж хүргүүлсэн. Нийт 13 төрлийн бичиг баримтыг боловсруулсан. 2025.06.03-ны өдрийн 01/1843 тоот албан бичгээр ЗГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2025.06.04-ний өдрийн 26 дугаар хуралдаанаар хэлэлцэн УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов. Шинэ Засгийн газар байгуулагдсантай холбогдуулан хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг дахин батлуулах шаардлага үүссэний дагуу 2025 оны 11 дүгээр сарын	90

						05-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд хуулийн төслийг танилцуулсан. ГБХДТХ-ийн төслийг боловсруулж хэлэлцүүлэхийг даалгасан ЗГ-ын 26-р хуралдааны тэмдэглэл гарсан. Хуулийн үзэл баримтлалыг 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр дахин хамтран баталсан. 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/4047 дугаар албан бичгээр холбогдох яамдаас санал авч байна.	
	1.3.Гэр бүлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт байгуулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үйлчилгээ үзүүлэх	Байгуулагдсан төвийн тоо өссөн дүнгээр	2	6	Улсын төсөв	Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв байгуулах аргачлал, зааврыг ГБХНХС-ын 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/92 дугаар тушаалаар баталж, ХГБХХЕГ-т чиглэл хүргүүлсэн. Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвөөр үзүүлэх үйлчилгээний загвар боловсруулж, тооцоо, судалгааг Орхон, Сэлэнгэ, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Батноров сум, Баянзүрх дүүргийн 1 хороонд тус тус хийсэн. ТНБД-ын 2025.11.10-ны А/300 дуугар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2025.11.20, 2025.12.03-ны өдрүүдэд 2 удаа хуралдаж алхамчилсан зааврыг боловсруулж байна. Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг ажиллуулахад ямар нэгэн барилга байшин шинээр барихгүй бөгөөд орон нутагт байгаа барилга, байгууламждаа түшиглэн ажиллуулах юм. 2025 онд Хэнтий аймгийн Батноров, Бор-Өндөр сум болон Баянзүрх дүүргийн 17, 12, 26, 21, 25 дугаар хороонд Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг загвар болгон байгуулан ажиллуулж эхлээд байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/3405 тоот албан бичгээр 2026 оны орон нутгийн төсөвт цогц төвийг ажиллуулах зардлыг тусгуулах чиглэлийг бүх шатны Засаг дарга нарт болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарт хүргүүлээд байна. Улсын нэгдсэн төсөвт энэ үйл ажиллагаанд тусгайлан батлагдсан төсөв тусгагдаагүй. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон нутгийн барилга байгууламж, хүний нөөцийг түшиглэн гэр бүлийн үйлчилгээний төв байгуулж, тухайн орон нутгынхаа хүн амын хөгжил, оролцоог дээшлүүлэх заавар боловсруулсны дагуу эхний ээлжид төсвийн хүндрэлтэй байгаа ч сум,	50

						хороонд өөрсдийн нөөцөд тулгуурлан төвийг нээн ажиллуулж байна. 100	
	Хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн үйлчилгээний төрөл, өссөн дүнгээр	-	3	Улсын төсөв		Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн заавар, зөвлөмжийг ГБХНХ-ын сайдын 2025.04.16-ны А/92 тушаалаар батлуулсан. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ернхий газар /ГБХХЕГ/-т хэрэгжилтийг зохион байгуулан орон нутгийн Засаг дарга нартай хамтран хэрэгжүүлэх чиглэлийг өгсөн. Эхчүүд, эмэгтэйчүүдэд зориулсан нийгмийн үйлчилгээг үзүүлэхээр төлөвлөн үйлчилгээний зураглал, ахмад настанд чиглэсэн хөтөлбөрийн төслийг тус тус боловсруулсан. Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвөөр үзүүлэх үйлчилгээний загвар боловсруулж, тооцоо, судалгааг Орхон, Сэлэнгэ, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Батноров сум, Баянзүрх дүүргийн 1 хороонд тус тус хийсэн. ТНБД-ын 2025.11.10-ны А/300 тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2025.11.20, 2025.12.03-ны өдрүүдэд 2 удаа хуралдаж алхамчилсан зааврыг боловсруулж байна. 30	
	Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	418,139	440,000	Улсын төсөв		- 21 аймаг, 9 дүүргийн газар, хэлтсүүдээр дамжуулан гэр бүлийн хөгжлийн үйлчилгээг 31 төв, танхимаар дамжуулан үзүүлж, 2025 оны 11 сарын байдлаар 97101 иргэн, үүнээс 55233 насанд хүрэгч, 39706 хүүхэд, 16335 хосод зөвлөгөө, мэдээлэл өгч, сэтгэл зүйн болон гэр бүлийн асуудлаарх хууль эрх зүйн зөвлөгөөг 59021 иргэнд өгч гэр бүлийн боловсрол олгох сургалтад 376433 иргэнийг хамруулсан. 30	
1.4.Хиймэл оюун ухааныг ашиглан иргэний хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлэх, сайжруулах	EFamily цахим платформд хандалт, өссөн дүнгээр /мян.хүн/	-	30.0	Улсын төсөв		е-family системийг хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулах зөвлөх үйлчилгээний даалгаврыг боловсруулан батлуулсан. И-монгол платформ дээр гэр бүлтэй холбоотой цэс үүсгэж хөтөч, зөвлөмж, гэр бүлтэй холбоотой үйлчилгээнүүдийг иргэд нэг дороос авах боломжтой болсон. • Гэр бүлийн цэсэд холбосон нийт 8 төрийн цахим үйлчилгээг холбож 2025 оны 01 сарын 01-ээс 2025 оны 12 сарын 31-ны хооронд давтагдсан тоогоор нийт 101,675 иргэн ашиглаад байна.	100
1.5.Сум, хороо бүрд хүүхэд, гэр	Илрүүлж, холбон	-	7200	Улсын төсөв		МУ-ын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.7-д "Сум, хороо бүрд нийгмийн	100

	бүлийн нийгмийн ажилтан ажиллуулж, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	зуучилсан эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, өссөн дүнгээр				ажилтан ажиллуулна" гэсэн зорилт дэвшүүлсэн. 2024 онд Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, уг хуулийн 58 дугаар зүйлд 2025 оны 01-р сараас эхлэн сум, хороодод хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллахаар заасан. Дээрх үндэслэлээр Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 237 дугаар тогтоол гарч, тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлал", 2 дугаар хавсралтаар "Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоо"-г нийслэлд 268, орон нутагт 565, нийт 833 албан хаагч ажиллахаар тогтоосон. 2025 оны 12-р сарын 05-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 773 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг сонгон шалгаруулж, ажиллуулж байна. Нийгмийн ажилтан ажиллаж эхэлснээр хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, анхан шатанд эрслэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй ажиллаж байна. Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар давхардсан тоогоор 124488, давхардаагүй тоогоор 21000 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн. Үүнд: 1/Шуурхай тусламжийн үйлчилгээнд 28504, 2/Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд 13066. 3/Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 82918 хүүхдийг тус тус хамруулсан. Жилийн эцсийн байдлаар эрсдэлт нөхцөлд амьдарч буй 9953 хүүхдийг шинээр эрсдлийн программд бүртгэж, насанд хүрсэн, эрсдлэгүй болсон 1801 хүүхдийг бүртгэлээс хассан. Нийт эрсдлийн программд бүртгэлтэй 22773 хүүхэд байгаагаас эрсдлийн түвшин өндөр 2640, дунд 5883, бага 7274, эрсдэлт өртөх магадлалтай 6976 хүүхдийг бүртгэсэн. Эрсдлийн программд бүртгэлтэй хүүхдээс шуурхай туламжийн үйлчилгээнд 15620 хүүхэд хамрагдаж анхан шатны нөхцөл байдлын үнэлгээг 13436 хүүхдэд хийж, 5120 хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажилласан. Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг гэр бүлээс тусдаа орчинд давхардсан тоогоор 21230 хүүхдэд, гэр бүлээс	
--	---	--	--	--	--	--	--

						тусдаа орчинд давхардсан тоогор 14720 хүүхдэд үзүүлсэн. Мөн эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, түүний гэр бүлд чиглэсэн зорилтот урьдчилан сэргийлэх, нөлөөллийн ажлын хүрээнд 1604 арга хэмжээг зохион байгуулсан. Эрсдэлт нөхцөлд амьдарч буй 9953 хүүхдийг шинээр илрүүлж үйлчилгээнд хамруулж байна.	
Зорилт 2. Хүн амын бүлгүүдийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	2.1.Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж, гэр бүл төвтэй, салбар дундын хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлэх	Кейс менежментийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, хувиар	69.3	75	Улсын төсөв	2025 оны байдлаар эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 36504 хүүхдэд хүүхэд хамгааллын кейс менежментийн төлөвлөлт гарган хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг бүрэн хүргэж, үр дүн гарсан 27082 хүүхдийн кейсийг хааж, шийдвэрлэлт 74.1 хувьтай байна. Хүүхэд хамгааллын кейс менежментийн төлөвлөлтийн дагуу хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үргэлжлүүлэн үзүүлж байгаа 9422 хүүхэд байна. 90	100
		Хүүхэд хамгааллын бодлоготой байгууллага, хувиар	3.7	25	Улсын төсөв	Улсын хэмжээнд 2025 оны байдлаар 16585 байгууллага хүүхэд хамгааллын бодлого мөрдөн ажиллаж байна. Үүнээс, Хүүхэд хамгааллын бодлогоо шинээр баталсан байгууллага өссөн дүнгээр 5416, эцэг, эхийн зөвлөл байгуулсан байгууллага өссөн дүнгээр 9828, хүүхдийн өрөө тохижуулсан байгууллага өссөн дүнгээр 1224, хүүхдийн цэцэрлэг байгуулсан байгууллага өссөн дүнгээр 117 байна. Нийт 2025 оны 12 дугаар сарын 01-ний байдлаарх төр, хувийн хэвшлийн 60657 байгууллагад харьцуулахад 27.3 хувьд хүрчээ. 100	
		Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхдээс нийгэмшүүлэх хөтөлбөрт хамрагдах хүүхэд, хувиар	54	80	Улсын төсөв	1/ Нийгэмшүүлэх арга зүйн хөтөлбөрт Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээнд хамрагдаж байгаа гэмт хэргийн сэжигтэн 204, зөрчил үйлдэж шийтгэгдсэн 304, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 297 нийт 805 хүүхэд бүртгэлтэй байгаагаас 658 хүүхдийг нийгэмшихүйн хөтөлбөрт хамруулах төлөвлөгөө гарган ажиллаж, 100 хувь хамрагдсан. 2/ Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх төслийн хүрээнд хууль зөрчсөн өсвөр насны хүүхдэд хэрэгжиж буй “Нийгэмшихүйн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажилладаг албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг аймаг, дүүргийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа	

						хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нийт 85 албан хаагчид зохион байгуулсан. 100	
	2.2.Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог иргэд, олон нийтийн оролцоотой бүрдүүлж, гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулах	Илрүүлж, холбон зуучилсан эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, өссөн дүнгээр	-	7200	Улсын төсөв	1.Зорилтот урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, түүний гэр бүлд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээ, аян, цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх зэрэг нийтийг хамарсан 351 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 114,729 хүүхэд, 91,820 насанд хүрэгчийг хамруулсан байна. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлт өртөхөөс урьдчилан сэргийлэх олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, мэргэжилтэн албан хаагчдыг ажлын байранд чадавхжуулах ажлыг 21 аймаг, нийслэл дүүргийн хэмжээнд “Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ”-ний хүрээнд зохион байгуулж, тус үйлчилгээгээр нийслэлийн 9 дүүргийн 225 хороо, 17 аймгийн 122 сумд хүрч ажилласан. -Урьдчилан сэргийлэх, хөгжлийн сургалт үйл ажиллагаанд нийт 157,323 хүүхэд, 239,397 эцэг эхчүүдийг хамруулж, 722 хамтарсан багийн 6,032 гишүүн, 801 сургуулийн нийгмийн ажилтан, 18,550 ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг арга зүйн удирдлагаар хангасан. Гэр бүлийн орчинд хүүхэд хамгааллыг сайжруулах, эцэг эх, асран хамгаалагч, иргэд олон нийтэд хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Хүүхэд хүмүүжлийн эерэг арга, Сайн эцэг эх байх зарчим, Гэр бүлийн харилцаа, Гэр бүлийн баяр хөөр, Гэр бүл төлөвлөлт зэрэг 64 удаагийн сургалт, 22 аян, 7 нэвтрүүлэг, 10 зөвлөгөөн, 32 өдөрлөг зохион байгуулсан байна. Тус арга хэмжээнд 157,323 хүүхэд, 239,397 эцэг эцэг, эх асран хамгаалагчийг хамруулсан. 2. 1/ Төсвийн Ерөнхийлөн захирагчийн аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гэрээнд Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, аймаг, дүүрэгт Олон нийтийн байцаагч ажиллах арга хэмжээг тусгасан.	100

					3/ 2025 оны жилийн эцсийн байдлаар эрсдэлт нөхцөлд амьдарч буй 9953 хүүхдийг шинээр илрүүлсэн. Эрсдэлийн программд бүртгэлтэй хүүхдээс шуурхай тусламжийн үйлчилгээнд 15,620 хүүхэд хамрагдаж, анхан шатны нөхцөл байдлын үнэлгээг 13436 хүүхдэд хийж, 5120 хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажилласан байна. Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг гэр бүлийн болон гэр бүлээс тусдаа орчинд үзүүлж ажилласан бөгөөд гэр бүлийн орчинд давхардсан тоогоор 21,231 хүүхэд, гэр бүлээс тусдаа орчинд давхардсан тоогоор 14,720 хүүхдэд үйлчилгээ үзүүлж ажилласан байна. Мөн эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхэд, түүний гэр бүлд чиглэсэн зорилтот урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 1604 сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж 59,464 хүүхэд, 65,824 эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулж ажилласан.	
2.3.Хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, эмэгтэйчүүдийн болон ганц бие эх, эцгийн хөдөлмөр эрхлэлт, асрахуйн эдийн засгийг дэмжих бодлого баримтлах	Нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль, тоогоор	-	1	Улсын төсөв	1/ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-т заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас аймаг, дүүргийн Засаг даргаас үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан өдөр өнжүүлэх төвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулсан. - Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас Боловсролын ерөнхий хууль 2024 оны 01 сараас хэрэгжиж эхэлсэн өдрөөс “Өдөр өнжүүлэх төвд тавих нийтлэг шаардлага” хүчингүй болсон байгаа тул Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас уг үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг хамтран боловсруулж, батлах саналыг Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлж, хамтран ажиллахаар төлөвлөж байна. Стандартын хүрээг тодорхойлж саналаа маягтаар хүргэх ажил эхлэлийн шатанд байна. 2/ Хүүхэд харах үйлчилгээ нь Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн дагуу 1-5, 9-12 дугаар саруудад зохион байгуулагддаг. 2025 оны Хүүхэд харах үйлчилгээний төсөвт 3,6 тэрбум төгрөг батлагдаж Боловсролын ерөнхий газраас сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийн судалгаа, аймаг, нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас хүүхэд харах үйлчилгээ эрхлэх хүсэлтэй ганц	90

					бие эцэг, эхийн судалгаа, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Батлан хамгаалах яамнаас хүүхэд харах үйлчилгээ шаардлагатай байгаа салбар, нэгж, хилийн заставд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаагүй, тус үйлчилгээ шаардлагатай байгаа хүүхдийн судалгааг нэгтгэн авч, судалгаанд үндэслэн хамрагдах хүүхдийн тооны дээд хязгаарыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2025 оны А/27 дугаар тушаалаар 1678 байхаар баталсан. 3/ Асрахуйн эдийн засгийг дэмжих хүрээнд Хүүхэд харах үйлчилгээ эрхэлж ганц бие эцэг эхийн судалгааг анх удаа гаргасан бөгөөд хагас жилийн байдлаар 18 иргэн байна. Цаашид Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх ганц бие эцэг, эхийг дэмжих бодлого баримталж байна. НҮБХХ-тэй хамтран Асрахуйн эдийн засагт хөрөнгө оруулах нь хэлэлцүүлгийг 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр зохион байгууллаа. Энэхүү хэлэлцүүлэгт олон талт оролцогчдын төлөөлөл 70 хүн оролцсон. Хэлэлцүүлгийн үр дүнд НҮБХХ-тэй хамтран асрахуйн эдийн засгийг бэхжүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэхээр болсон. Энэ ажлын хүрээнд “Монгол Улсад асрахуйн эдийн засгийг бэхжүүлэх нь” төслийн баримт бичигт санал авахаар бодлогын газруудад дотоод албан бичиг хүргүүлж, ирсэн саналыг нэгтгэн тусгаж 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл /ХЭҮЗ/-ийн хурлаар батлуулсан “2025 оны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөр”-т дараах зохицуулалтыг тусгасан. Үүнд: -Бага насны хүүхэд болон байнгын асаргаатай хүнийг асарч байгаа иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор санхүүгийн дэмжлэг олгох мөн бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулах; -Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээгээр дамжуулан ажлын байранд зуучлах, ажлын байранд дасан зохицож байнгын ажилтай болоход дэмжлэг үзүүлэх.	
--	--	--	--	--	--	--

					Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд асрахуйн эдийн засгийг дэмжих зохицуулалтыг тусган боловсруулсан. Хуулийн төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авахаар 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 01/1870 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Түүнчлэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох материалын хамт 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1886 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Хүүхэд харах үйлчилгээг зорилтод бүлэг, алслагдсан бүс нутаг, хилийн застав, цэргийн ангийн ажилтнуудын хүүхдийг хамруулах, ганц бие эцэг эхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого баримтлан ажиллаж байна. Хүүхэд харах үйлчилгээний 142 төвд хагас жилийн байдлаар 329 хүүхэд харагч ажиллаж, 1455 хүүхэд хамрагдсанаас 189 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдсан бол жилийн эцсийн байдлаар 13 аймгийн, 6 дүүргийн 123 төвд 261 хүүхэд харагч ажиллаж 11,533 хүүхэд хамрагдсанаас 127 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. 12 сарын байдлаар хүүхэд харах үйлчилгээний журам, стандартын дагуу мэдээллийн санг шинэчилж, хүүхдийн ирцийн мэдээний маягт, бүртгэлийн хуудсыг хянан жилийн эцсийн байдлаар 2,696,381,673 төгрөгийн санхүүжилт олгосон. Хүүхэд харах үйлчилгээнд алслагдсан бүс нутаг, зорилтот бүлгийн 398 хүүхэд хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 68,9 хувиар өссөн байна. Жилийн эцсийн байдлаар 123 хүүхэд харах үйлчилгээний төв ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20,5 хувиар буурсан байна. Хамрагдсан хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 2,8 хувиар буурсан. Хүүхдийн тоо буурсан шалтгаан нь сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт нэмэгдсэн, улирлын хяналт шалгалтын үр дүнд нэг төвд хамрагдах хүүхдийн тоог стандартад нийцүүлж, зөрчлийг арилгуулсантай холбоотой байна. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хамрагдалтын судалгааг 1 дүгээр сарын 03-ны өдрийн 01/08 дугаартай албан бичгээр Боловсролын ерөнхий	
--	--	--	--	--	--	--

					газраас нэгтгэн авсан. Судалгаанд үндэслэн агентлагийн даргын А/27 тушаалаар Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах хүүхдийн дээд хязгаар, үйлчилгээг үр дүнтэй, хүртээмжтэй зохион байгуулах арга зүйн удирдамжийг баталсан. Агентлагийн даргын 2025 оны А/29 тушаалаар сарын тайлан авах маягт, Засгийн газрын 97 тогтоолын 3.1 дэх хэсэгт заасны дагуу хүүхэд харах үйлчилгээний нэгдсэн мэдээллийн сангийн маягтыг тус тус шинэчлэн баталж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан 17 аймаг, 8 дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, хэлтэст 01/128 албан тоотоор, хүүхэд харагчийг бэлтгэх сургалтыг зохион байгуулах чиглэлийг 01/148 албан тоотоор тус тус хүргүүлж ажилласан. Үүний үр дүнд шинээр 158 хүүхэд харагч бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеэс 58,9 хувиар өссөн байна. Жилийн эцсийн байдлаар хүүхэд харах үйлчилгээг үр дүнтэй, хүртээмжтэй зохион байгуулах мэргэжил арга зүйн удирдлагаар хангах танхим болон цахим хурал, сургалтыг 2 удаа зохион байгуулж 52 албан хаагчийг оролцуулсан. Асрахуйн эдийн засгийг дэмжих хүрээнд хүүхэд харах үйлчилгээ эрхэлж буй ганц бие эцэг, эхийн судалгааг гаргахад 20 иргэн байна. Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, холбогдох журам, стандартын хэрэгжилтийн хүрээнд улирал бүр нэгдсэн хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, тайлан, мэдээллийг нэгтгэн, илэрсэн зөрчил дутагдлын арилгуулсан. Хяналт, шалгалтаар 14 зөрчил илэрснийг газар дээр нь арилгаж, цаашид дахиж гаргахгүй байх зөвлөмж өгч ажилласан. Жилийн эцсийн байдлаар стандартын хэрэгжилт 95%-тай байна. Хяналт, шалгалтаар илэрсэн 58 зөрчил илэрсний 46 хүүхдийн эрхийн улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж, 3 төвийг хаах хүртэл арга хэмжээ авсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар хууль, журам стандартын хэрэгжилтийн хувь 100 хувь байна. Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Ханбогд сумын Цагаан хад хилийн боомтын сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаагүй хүүхдийн	
--	--	--	--	--	--	--

						нөхцөл байдалтай танилцан шинээр 10 хүүхдийн 2 хүүхэд харах үйлчилгээний төвийг шинээр байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.	
	2.5. "Ахмадын сан"-ын зарцуулалт, үр нөлөөний үнэлгээ хийж, ахмадын сангийн ач холбогдлыг сурталчлах	Үр нөлөөний үнэлгээ, зөвлөмж	-	1	Улсын төсөв	Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" гэсэн нэмэлт өөрчлөлт оруулсан. Мөн Компанийн тухай хуульд нэмэлт оруулж хуулийн 16 дүгээр зүйлд Компанийн дүрэмд Ахмадын санг байгуулан ажиллуулах асуудлыг нэмж тусгасан. Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2024 оны "Журам шинэчлэн батлах тухай" 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ыг шинэчлэн баталсан бөгөөд журмаар дараах асуудлыг тодорхой тусгасан. Үүнд: -Аж ахуйн нэгж байгууллага, төсвийн байгууллага нь ахмад настны тооноос хамааран санг цалингийн сангийн хэдэн хувиар тогтоох асуудлыг хоёр жилд нэг удаа байгууллагын дэргэдэх ахмадын хороо, зөвлөлтэй хэлэлцэн тогтоож, нийт ажилтны хуралд танилцуулах, - Ахмадын сангийн хөрөнгө нь тухайн байгууллагын төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэг байх, -Төсвийн байгууллага нь санд шилжүүлэх хөрөнгийг төсвийн төлөвлөлтийн Фискал программын "Ахмадын сан" гэсэн зориулалтад тусган батлуулж, санхүүжүүлэх; -Төсвийн байгууллага нь санд шилжүүлэх хөрөнгийг төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 42.3-т заасны дагуу төсөвтөө зохицуулалт хийх саналаа гаргаж, шийдвэрлүүлэх; -Төсвийн байгууллагын удирдлага нь сан байгуулан ажиллуулах тухай тушаалыг баталж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлтээ хүргүүлэн сангийн дансыг нээлгэх.	30

					Ахмадын сангийн хэрэгжилтийг сайжруулах, журмыг хэрэгжүүлэх зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/634 дугаартай "Ахмадын сан байгуулах тухай" албан бичгийг Засгийн газрын бүх гишүүдэд хүргүүлсэн. Мөн 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/1941 дугаартай "Ахмадын сан байгуулсан болон тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөр баталж, хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага"-ын судалгааг ирүүлэх тухай албан бичгийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус хүргүүлэн ажиллаж байна. ГБХНХЯ, Монголын ахмадын холбоотой Ахмад настны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр жил бүр гэрээ байгуулан, хамтран ажиллах төлөвлөгөө баталж ажилладаг бөгөөд уг төлөвлөгөөнд Ахмадын сангийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг тусгадаг. Монголын ахмадын холбооноос аймаг, дүүргийн ахмадын хороодод тодорхой чиглэл өгч, ахмадын хороод тухайн нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, төсөвт байгууллагад мэдээлэл, өгч сургалт зохион байгуулж хамтарч ажилласан. Үүний үр дүнд 2025 онд 2800 гаруй аж ахуйн нэгж байгууллага Ахмадын сан байгуулаад байна.	
2.6.Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийж, хэрэгжилтийг эрчимжүүлэх	Үнэлгээ, зөвлөмж	-	1	Улсын төсөв	Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд: "Ажилтныг тэтгэвэрт бэлтгэх арга зүй, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жишиг загвар"-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/121 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Хэрэгжилтийн мэдээллийг аймаг, дүүргээс авч дүн шинжилгээ хийхээр ажиллаж байна. Жишиг загвар нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацаа дөхсөн ажилтны нийгмийн оролцоог дэмжих, эдийн засгийн баталгааг хангах, орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хадгалж, тэднийг байгууллага, хамт олныхоо дэмжлэгээр ажил хөдөлмөрийн идэвхтэй үеэс амьдралын дараагийн үедээ сэтгэл хангалуун шилжих боломжийг бүрдүүлэх зорилготой. Ажилтныг тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийг нийт 14,772 аж ахуйн нэгж байгууллага хэрэгжүүлсэн. Үүнээс: - 2020 онд 4414	50

						- 2021 онд 6770 - 2022 онд 1028 - 2023 онд 710 - 2024 онд 650 Монголын ахмадын холбоо аймаг, дүүргийн ахмадын хороодоос аж ахуйн нэгж, байгууллагад ахмад ажилтны “Тэтгэвэрт бэлтгэх” төлөвлөгөө баталж хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний сургалт, зөвлөгөө, санхүүгийн дэмжлэг болон төрийн бусад үйлчилгээтэй уялдуулан зохион байгуулж ажилласны үр дүнд 2025 онд 1200 гаруй аж ахуйн нэгж, байгууллага Ахмад настны тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөтэй болсон. “Ажилтныг тэтгэвэрт бэлтгэх арга зүй, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жишиг загвар”-ыг шинэчлэн боловсруулж батлуулахаар 2026 оны төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.	
		Төлөвлөгөө баталсан аж ахуйн нэгжийн тоо, өссөн дүнгээр	650	715		Ажилтныг тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийг 2025 онд 1200 аж ахуйн нэгж, байгууллага байгуулсан байна.	
Зорилт 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хөгжил, хамгааллын чиглэлээрх эрх зүйн орчныг шинэчилж, боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах	3.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлэх	Өргөн мэдүүлсэн хуулийн төсөл	-	1	-	ГБХНХ-ын сайдын 2025 оны А/22 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг тайлант хугацаанд 3 удаа зохион байгуулж, хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандалт судалгааг боловсруулсан. Мөн дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2025 оны 09 болон 12 дугаар сарын 09-ний өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран баталсан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг боловсруулсан.	50

	3.2.Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх	Өргөн мэдүүлсэн хуулийн төсөл	-	1	-	ГБХНХ-ын сайдын 2025 оны А/22 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг тайлант хугацаанд 2 удаа зохион байгуулж, хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандалт судалгааг боловсруулсан. Мөн дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. УИХ-ын гишүүн О.Саранчулуун хууль санаачлах эрхийнхээ хүрээнд Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг УИХ-д өргөн барих хүсэлтийг тус яаманд тавьсан тул боловсруулсан хуулийн төсөл, холбогдох судалгаа, баримт бичгийг 2025 оны 08 дугаар сард УИХ-ын гишүүн ажлын албанд хүлээлгэн өгсөн.	ҮБ
	3.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан хүний тоо /мян.хүн/	50,0	5,0	Улсын төсөв Бусад эх үүсвэр	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан аяны хүрээнд нийт 143 постер, видео контентийг олон нийтэд түгээж, хэвлэл мэдээллийн 12 байгууллагатай хамтран ажилласан. Салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх сургалтыг нийт 209 удаа зохион байгуулж, 10,124 иргэнийг хамруулсан байна. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн хүрээнд салбар дундын уялдааг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг хүргэх, иргэд, ажил олгогчдын ойлголт, хандлагыг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг Хөвсгөл аймагт 2025 оны 04 дүгээр сард, Дундговь аймагт 2025 оны 05 дугаар сард, Баян-Өлгий аймагт 2025 оны 10 дугаар сард, Улаанбаатар хотод 12 дугаар сард тус тус зохион байгуулав. Тус арга хэмжээнд нийт 4,472 иргэн тус тус хамрагдсан байна. Тус яамнаас "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар	100

					комисс"-ын гишүүдийг чадавхжуулах сургалтыг бүсчлэн зохион байгуулж, нийт 20 аймаг, дүүргийн салбар комиссын 132 гишүүнийг сургалтад хамруулсан. АХБ-ны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд дараах 3 сургалтыг зохион байгуулсан. Үүнд: 1. Хүүхдийн эрт үеийн хөгжлийн дэмжлэг, оролцооны Портеж хөтөлбөрийн орон нутаг дахь сургагч багшаар бэлтгэх сургалтыг 2025 оны 9-10 дугаар сард зохион байгуулж, нийт 30 үндэсний сургагч багш бэлтгэж сертификат олгосон. 2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөлдөх бүлгийг чиглүүлэх ажилтанд ур чадвар эзэмшүүлэх сургалтыг 10 дугаар сарын 29-31-ний өдөр Улаанбаатар хотод зохион байгуулж, сургалтад ГБХНХЯ, ХБХХЕГ, СЗСҮТ, Архангай, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Ховд, Хөвсгөл аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Түгээмэл хөгжил ТББ зэрэг байгууллагаас нийт 30 гаруй оролцогч хамрагдсан. 3.Харааны бэрхшээлтэй иргэдтэй харилцах арга зүйн сургалтыг 2025 оны 7 дугаар сарын 01-02-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан. Уг сургалтад ГБХНХЯ, ХБХХЕГ, ХБИХЭДТ, ХБХХТ-ийн ажилтнууд зэрэг 30 оролцогч хамрагдсан.	
3.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хөгжүүлэх	Үйлчилгээний тоо	-	3	Улсын төсөв	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр эрхлэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөдөлмөр эрхлэхэд зориулж хувийн туслахын үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ, хувийн туслах бэлтгэх сургалт зохион байгуулах, олон нийтэд түгээх арга хэмжээнд 2025 онд 740 сая төгрөгийн төсөв батлагдсан. Тайлант хугацаанд нийт 641.468.000 төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 86.7 хувьтай байна. Үүнд: 1.Хөгжлийн бэрхшээлтэй 57 иргэнд хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор хувийн туслах үйлчилгээг үзүүлж, 595.868.000 төгрөгийг зарцуулсан байна. 2.Хувийн туслах бэлтгэх сургалтад нийт 111 хүнийг бэлтгэж, 5.800.000 төгрөгийг зарцуулсан. 3.Олон нийтэд түгээх арга хэмжээний хүрээнд бие даан амьдрах нөлөөллийн ажилд 19.800.000 төгрөг, хувийн туслахын програм шинэчлэлийн ажилд 20.000.000 төгрөгийг зарцуулсан.	90
	Үйлчилгээнд хамрагдсан иргэд, тоогоор	150	500			

Ерөнхий чиг үүрэг: Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Үндсэн чиг үүрэг: Хөдөлмөрийн бодлого

Зорилт 2. Эрүүл, аюулгүй орчинд хөдөлмөрлөх эрхийг хангах	2.1.Төрийн албан хаагчдын үндсэн цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх	Нэмэгдэл хувиар	6	8	Улсын төсөв	Өнгөрсөн хугацаанд төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зарчмыг баримталж ирсэн бөгөөд төрийн албан хаагчийн цалин хөлсний бодлогын шинэчлэлийн хүрээнд 2022 оноос эхлэн цалингийн шатлалыг хялбаршуулахад чиглэсэн арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж байна. Уг бодлогыг үргэлжлүүлж Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын хүрээнд төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дунджаар 40 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Мөн 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Монгол Улсын 2025 оны улсын төсөвт тусгасны дагуу Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчдын үндсэн цалинг 6 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Уг арга хэмжээний үр дүнд төрийн захиргааны болон төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ 1,166.0 мянган төгрөг, төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээ 954.0 мянган төгрөг болсон. Эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухааны салбарын нэмэлт хэлэлцээрийн дагуу боловсролын салбарын албан хаагчдын үндсэн цалинг 50 хувиар, эрүүл мэндийн салбарын албан хаагчдын үндсэн цалинг 30 хувиар, шинжлэх ухааны салбарын албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар тус тус нэмэгдүүлэхээр болсон. Бусад салбарын төрийн албан хаагчдын цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	100
	2.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг	Өргөн мэдүүлсэн хууль, тоогоор	-	1	Улсын төсөв	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/21 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах техникийн ажлын хэсгийг байгуулан хуулийн төслийг боловсруулж, хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод	70

	боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх					хэргийн сайдтай 2025 оны 03 дугаар, 07 дугаар саруудад тус тус хамтран баталсан. Хуулийн төсөл боловсруулах хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалсан судалгаа, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн үнэлгээ, хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон дагалдаж нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг тус бүр боловсруулсан. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/88 дугаар тушаалаар хуулийн төслийг эцэслэн боловсруулах, хэлэлцүүлэх үүрэг бүхий өргөтгөсөн ажлын хэсгийг хөдөлмөр, нийгмийн түншлэгч талууд болон холбогдох байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй байгуулан, хуулийн төслийн хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулж, саналыг хуулийн төсөлд тусгасан. Мөн хуулийн төслийн хэлэлцүүлгийг орон нутгийн ажил олгогч, ажилтны төлөөлөл, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллүүдэд зохион байгуулж санал солилцон ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авахаар төрийн захиргааны төв байгууллагууд болох салбарын яамд, холбогдох байгууллагуудад 2025 оны 01/3857 тоот албан бичгээр хүргүүлсэн.	
	2.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, техникийн зохицуулалтыг үе шаттай шинэчлэх	Шинэчилсэн стандарт, техникийн зохицуулалтын тоо	1	2	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартуудад улсын үзлэг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг болон удирдамжийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/22 дүгээр тушаалаар баталж, улсын үзлэгийг зохион байгуулсан. Стандарт, хэмжил зүйн газраас ирүүлсэн 156 стандартыг улсын үзлэгт хамруулсан. Стандартын	90

					улсын үзлэгийн дүнгээр нийт 156 стандартын 47 нь буюу 30.1 хувийг нийтэд нь дахин хянах, 57 нь буюу 36.5 хувийг хүчингүй болгох, 46 нь буюу 29.5 хувийг хэвээр мөрдөх, 6 нь буюу 3.8 хувийг холбогдох заалтыг хянах, 22 нь буюу 14.1 хувийг техникийн зохицуулалт болгох нь зүйтэй гэж дүгнэсэн. Энэ ажлын үр дүнд үндэслэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, техникийн зохицуулалтын шинэчлэлийн 2025-2027 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 2025 оны А/97 дугаар тушаалаар батлуулсан. Дээрх улсын үзлэгийн тайланг Стандарт, хэмжил зүйн газарт 2025 оны 03/989 тоот албан бичгээр санал авахаар хүргүүлсэн. Мөн үзлэгийн дүнд үндэслэн Стандарт, хэмжил зүйн газрын хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны стандартчиллын техникийн хорооны хурлаар 38 стандартыг шинэчлэн батлуулсан. Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/118 дугаар тушаалаар “Асбесттэй харьцах аюулгүй ажлын техникийн зохицуулалт”, Хязгаарлагдмал орчинд ажиллах аюулгүй ажиллагааны техникийн зохицуулалт”-ын төслийг боловсруулан Засгийн газрын тогтоолын төсөлд санал авахаар салбарын яам болон холбогдох газарт танилцуулгын хамт 2025 оны 01/3812 тоот албан бичгээр хүргүүлсэн.	
Зорилт 3. Хөдөлмөр эрхлэлтийн хууль тогтоомжийг боловсронгуй болгон, шинэчлэх	3.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх	Өргөн мэдүүлсэн хууль, тоогоор Дагалдан гарах судалгааны тоо	Үзэл баримтлал -1	Шинэчилсэн найруулга-1 Холбогдох судалгаа-3	Улсын төсөв Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулах техникийн ажлын хэсгийг ГБХНХЯ-ны ТНБД-ын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/128 тоот тушаалаар байгуулж төслүүдийг боловсруулж, үзэл баримтлалын төслийг ХЗДХЯ-нд 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 01/1422 тоот албан бичгээр хүргүүлж батлуулсан. 2025 оны 7 дугаар сард Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан хуулийн үзэл баримтлалын төслийг дахин батлуулах шаардлага үүсч, улмаар 2025 оны 08 дугаар сард дахин батлуулсан. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэгдүгээрт, салбаруудын бодлогын уялдаа холбоог хангаж хөдөлмөр эрхлэлтийн баримжаатай болгох,	70

					хоёрдугаарт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний төрлийг нэмэгдүүлж, олон улсын жишигт хүргэх, хэрэглэгч төвтэй бүтэц, кейс менежментийн тогтолцоонд шилжүүлэх, гуравдугаарт, их өгөгдөлд суурилсан хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, ажиллуулах, дөрөвдүгээрт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсвийн төлөвлөлт бүхий олон эх үүсвэртэй, тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх, тавдугаарт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхтэй холбоотой бодлогын шинэчлэлийн агуулгуудыг тусган ажиллаж байна. Хуулийн төслийг холбогдох 3 судалгааны хамт боловсруулан Засгийн газрын гишүүдээс санал авахаар 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 01/1870 тоот, 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01/3088 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. Хуулийн төсөлд 13 салбарын яамдаас санал ирүүлж, саналыг нэгтгэн хуулийн төсөлд тусгах ажлыг хийсэн. Мөн Европын холбооны Sociex+ төслийн санхүүжилтээр "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг шинэчлэн найруулах замаар хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох" төслийг боловсруулан Европын холбооны хурлаар батлуулаад байна. Уг төслөөр Олон Улсын 2 зөвлөх Монгол Улсад 2025 оны 9-11 саруудад хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж, хуулийн төсөлд нарийвчилсан санал зөвлөмж өгч, хамтран ажилласан. ХЗДХ-н сайд 2025 оны 9 дүгээр сард солигдсонтой холбогдуулан хуулийн төслийн үзэл баримтлалыг дахин батлуулах шаардлага үүссэнтэй холбогдуулан хуулийн төслийг 2025 онд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулан хэлэлцүүлэх ажил хойшилсон. ХХХЭБГ	
--	--	--	--	--	--	--

Зорилт 4. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	4.1Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэх	Төслийн хэрэгжилт, хувиар	-	10	Гадаад зээл, туслам ж	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр Япон Улсын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран “Монгол улсын зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг 2025 онд эхлүүлэн ажиллаж байна. Уг төслөөр Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ахлах зөвлөх 16, зөвлөх 72 хүнийг бэлтгэж, хүний нөөцийн тогтолцоог бэхжүүлсэн. Мөн энэхүү төслийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 193 иргэн хамрагдаж, 46 иргэн ажил туршиж, 26 иргэн байнгын ажилд орсон. Уг төсөл нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хөгжүүлэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн үр дүнтэй загвар төсөл болон хэрэгжиж байна. Төслийн хэрэгжилт 10 хувьтай байна. Цаашид хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхээр 2027 оны 8 сар хүртэл хэрэгжинэ.	100
	4.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан Олон улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж байгуулж, хүртээмжийг нэмэгдүүлэх	Байгуулсан Жоб центр төвийн тоо, өссөн дүнгээр	4	30	Улсын төсөв Бусад эх үүсвэр	Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Олон Улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, нийгмийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгох” зорилтын хүрээнд улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг олон улсын жишигт нийцсэн байдлаар үзүүлэх, ижил стандарт бүхий “Job center” төвүүдийг байгуулахаар төлөвлөж, Улаанбаатар хотод 2024 онд эхний 4 төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн. “Job center” төвөөр үйлчлүүлсэнээр ажилгүй иргэн, ажил хайгч иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, ажил, мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл авах хүсэлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, оюутан залуучууд, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгч иргэн, гадаадад амьдарч байгаад эх орондоо болон ажил олгогч байгууллагууд нэг дор хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг авахаас гадна цагийн ажил, зайнаас ажиллах ажилд зуучлагдах боломж бүрдэнэ.	50

						“Олон Улсын жишигт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний Job center төвийг дэмжих туршилтын төсөл”-ийн хүрээнд 30 төвийг шинээр байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 2025 онд нийт 14 төвийг байгуулж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн.	
Зорилт 5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хүн амын бүлгүүдэд зориулан оновчтой хэрэгжүүлэх	5.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдсан хүний тоогоор	5479	5500	Улсын төсөв	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дугаар тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг шинэчлэн баталсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөр эрхлүүлэх, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, тэдгээрийн онцлог хэрэгцээнд нь нийцсэн тохируулгатай ажлын байр бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангах, ажил олгогчийг дэмжихэд чиглэсэн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 15.7 тэрбум төгрөг баталсан. Үүнд: 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд 3.4 тэрбум төгрөг; 2. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд 6.7 тэрбум төгрөг; 3. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 284.5 сая төгрөг; 4. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэхэд 740.0 сая төгрөг; 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажлын байр бий болгосон ажил олгогчид үзүүлэх дэмжлэгт 760.3 сая төгрөг; 6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 3.9 тэрбум төгрөг тус тус баталж үйл ажиллагааг эхлүүлээд байна. -Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн нэгдүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж төслийн сонгон шалгаруулалтад нийт 16 байгууллага шалгарсан байна. Үүнээс: 9 аж ахуйн нэгж байгууллагад 450 сая төгрөг, 7 байгууллагад 170 сая төгрөгийн санхүүжилтийг 100 хувийн эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр нийт 620 сая	30

					төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон бөгөөд энэхүү санхүүжилтээр 62 ажлын байр бий болгоно. -Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/34 дугаартай тушаалаар Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулсан. Гүйцэтгэх үйлчилгээ ХБХХЕГ/20250103002 дугаартай 350,000,000 (гурван зуун тавин сая) төгрөгийн нээлттэй тендерийг зарласан Давхардсан тоогоор нийт 39 байгууллага тендерийн материал ирүүлснээс дараах байгууллагууд шалгарч, гэрээ байгуулсан. Үүнд: Багц 2. Өмнөговь аймгийн 25-с дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх тендерт Тэгш хүртээмж бие даан амьдрах төв ТББ Багц 3. Өмнөговь аймгийн 25-с дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх тендерт Тэргэнцэртэй иргэдийн холбоо ТББ Багц 6. Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ-ууд шалгарч Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга 2025 оны 06 дугаар сарын 05-нд гэрээ байгуулсан. (Зарцуулсан төсөв: 232.700.000) Багц 3,4 төсөлд шаардлага хангасан байгууллага гараагүй учир дахин тендер зарлахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Бусад арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зарлахаар бэлтгэлийг хангаж байна.	
5.2.Залуучууд, ахмад настан, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	90	100	Улсын төсөв	2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл /ХЭҮЗ/-ийн хурлаар батлуулсан “2025 оны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөр”-т залуучууд, ахмад настан, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг тусгасан. Тухайлбал, залуучуудын гарааны бизнесийг дэмжих санхүүгийн хэмжээг нэмэгдүүлсэн. 2025 оныг “Залуучуудын жил” болгон зарласантай холбогдуулан Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас ирүүлсэн төлөвлөгөөнд хамтран	70

					ажиллахаар саналыг тусгаж, дэмжин ажиллахаа илэрхийлсэн. Монгол Улсын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг оновчтой тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын санхүүжилттэй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ҮЕР төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү төслийн хүрээнд залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж буй асуудлуудад дүн шинжилгээ хийж, хүний нөөцийн бодлого, бүтээмж, ажлын байрны менежментийг сайжруулах арга хэрэгслийг түгээн дэлгэрүүлж, холбогдох сургалтуудыг зохион байгуулж ажиллах бөгөөд ноос ноолуур болон зочлох үйлчилгээний салбарт туршин хэрэгжүүлэх юм. Азийн хөгжлийн банкны “Мэдлэгт тулгуурлан төсөлд инноваци, туршлагыг нэвтрүүлэх нь” техник туслалцааны төслийн дэмжлэгтэйгээр Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх судалгааны ажлыг хийхээр Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А/156 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Энэхүү судалгааг 2025 оны 7 дугаар сард багтаан дуусгах бөгөөд 9 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан Залуучуудын нэгдсэн форумд танилцуулсан. Нэгдсэн форумаар залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, цаашдын чиг хандлагын талаар хэлэлцүүлэг хийж, хэлэлцүүлгээс гарсан асуудлыг бодлогын баримт бичигт тусгаж, хууль эрхзүйн орчны хүрээнд мөн хэрэгжилтийн түвшинд шийдвэрлэж ажиллаж байна. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд: 1.Хувиараа хөдөлмөр эрхлэх ахмад настанд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг өмнөх жилүүдийнхээс нэмэгдүүлсэн; 2.Ахмад настны зөвлөх үйлчилгээний төрөл, хэлбэрийг нэмэгдүүлсэн; 3.Хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх ахмадуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ажиллаж байсан ажил мэргэжлийн чиглэлийг заахгүйгээр сонгон шалгаруулж ажиллах боломжийг бүрдүүлсэн. 2025 онд:	
--	--	--	--	--	--	--

					- Мод тарих арга хэмжээнд 2,557 иргэн хамрагдаж, 2,557 иргэн түр ажлын байраар хангагдаж, 1,198,757,600 төгрөгийг; - Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 1109 иргэн хамрагдаж, 1109 иргэн түр ажлын байраар хангагдаж, 1,065,753,000 төгрөгийг; - Ахмадын холбоо, төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээнд 29 ТББ хамрагдаж, 186 иргэн түр ажлын байраар хангагдаж, 271,565,800 төгрөгийг; - Хүүхдийн эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 224 иргэн хамрагдаж, 224 иргэн түр ажлын байраар хангагдаж, 324,544,800 төгрөгийг тус тус зарцуулсан байна. Ахмадад санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1094 иргэн хамрагдаж, 1,162 иргэн ажлын байраар хангагдаж, 7,586,500,000 төгрөгийг тус тус зарцуулсан байна. ХЭҮЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны бүхий л арга хэмжээнд эмэгтэйчүүдийн оролцоог хангах, тэдний бүрэн болон бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэх боломжийг хангаж өгсөн. Тодруулбал, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд байнгын ажлын байранд зуучлах, цагийн ажил эрхлэхийг дэмжих, гэрээс зайнаас ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ур чадварын цахим сургалтыг зохион байгуулах, өрхийн бизнес, аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэнд санхүүгийн дэмжлэг олгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ. 2025 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн 51 хувь нь эмэгтэйчүүд, 35.5 хувь нь 18-34 насны залуучууд байна.	
5.3.Хувиараа хөдөлмөр эрхлэгч, гарааны бизнес эрхлэгчийг дэмжих замаар албан бусаас албан хэлбэрт шилжих	Тухайн жилд хэрэгжүүлсэн хөтөлбөр, тоогоор	-	1	Улсын төсөв, Гадаад ын зээл, тусламж	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар 2025 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа /хөтөлбөр/-г баталсан. Энэ хүрээнд албан бусаас албан хөдөлмөрт шилжүүлэхтэй бодлоготой холбоотой хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах	100

	хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх					иргэнийг дэмжих зорилготой санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааг хэрэгжүүлж, 3300 иргэнийг хамруулж 37.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Түүнчлэн хувиараа хөдөлмөр эрхлэгч, гарааны бизнес эрхлэгчийг дэмжих жижиг, дунд бизнесийг дэмжих зээл, зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах чиглэлээр Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, Засгийн газрын 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 267 дугаар тогтоолоор батлуулсан. 2025 онд санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаанд 5369 иргэн, ААНБ-ыг хамруулсан байна.	
5.4.Хилийн чанадаас эх орондоо эргэн суурьших Монгол иргэдэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх	Хөтөлбөрт хамрагдсан иргэд, тоогоор	-	100	Улсын төсөв	НҮБ-ын Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллагатай гадаадад ажиллаж, амьдарч байгаа Монгол иргэд болон Монгол Улсад ажиллаж байгаа гадаадын ажилчдын асуудлаар хамтран ажиллах чиглэлээр санал солилцон хамтран ажиллаж байна. Тус байгууллагын гадаадад суралцаж, ажиллаж байгаа өндөр ур чадвартай иргэдийг эх орондоо эргэн ирэх, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжих чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа судалгаа, туршилтын хөтөлбөрийн ажлын даалгавартай танилцан санал хүргүүлсэн. Мөн хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан санамж бичгийн дагуу БНСУ болон Япон улсад хууль ёсоор хөдөлмөр эрхэлж байгаа, нутаг буцах хугацаа нь дөхсөн иргэдийн судалгаа, мэдээллийг гаргах, хөдөлмөр эрхлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, холбогдох дэмжлэгийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр холбогдох судалгааг хийж байна . ГБХНХЯ, ХХҮЕГ-аас БНСУ болон Япон улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаад эх орондоо эргэн ирсэн иргэд, мөн гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдийг бүртгэж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээ, мэдээллээр хангах, сургалтад хамрагдах, бичил бизнес эхлүүлэхэд нь	30	

						дэмжлэг үзүүлэх зорилгоор 2025 оны 12 дугаар сарын 5-ны өдөр “Хөдөлмөр-Хөгжил” өдөрлөгийг зохион байгуулсан. Тус өдөрлөгийн үеэр ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгалын бодлого, хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний талаар иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, сурталчлан таниулах, санал хүсэлтийг хүлээн авч ажилласан. Өдөрлөгт ЖДҮГ, НДЕГ, дүүргүүдийн ХХҮГ болон Япон, Солонгос хэлний сургалтын байгууллагууд оролцож 11 иргэнд үнэ төлбөргүй сургалтад хамрагдах эрхийн бичиг гардуулан өгсөн. Мөн өдөрлөгийн үеэр иргэдэд үйлчилгээг “Өртөөчилсөн булан” хэлбэрээр үзүүлсэн нь онцлог болсон ба нийт 350 иргэн үйлчлүүлсэн.	
Ерөнхий чиг үүрэг: Нийгмийн халамж, үйлчилгээний							
Үндсэн чиг үүрэг: Нийгмийн халамжийн бодлого							
Зорилт 1. Нийгмийн халамжийн үйлчилгээний зүйн орчныг шинэчилж, боловсронгуй болгох	1.1.Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлж батлуулах	Өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /тоо/	-	1	Улсын төсөв	Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2024.12.20, 2025.09.25, 2025.12.15-ны өдрүүдэд Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 3 удаа хамтран баталсан. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан. Энэ хуулийн төсөлтэй холбогдуулан 21 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслүүдийг боловсруулсан. 2025 онд яамдаас ирүүлсэн 2 удаагийн саналыг тусган хуулийн төслийг сайжруулан боловсруулж Улсын Их хуралд өргөн мэдүүлэхэд бэлэн болсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ, зардлын тооцоо, дэлгэрэнгүй болон товч танилцуулга, үр нөлөөний үнэлгээ, хэлэлцүүлгүүдийн тайлан зэрэг иж бүрдлийг бүрэн хангасан.	70
	1.2.Нийгмийн халамжийн холбогдох журмыг шинэчлэн батлуулах	Батлагдсан баримт бичиг /тоо/ /1.Нийгмийн халамжийн	-	3		1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах: Засгийн газрын 2021 оны 362 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам”-ыг хэрэгжүүлэх явцад гарсан	70

		тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах 2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хөнгөлөлт, тусламж үзүүлэх журмыг шинэчлэн батлуулах 3.Хүнсний эрхийн бичиг олгох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах /			тэтгэвэр, тэтгэмж олгох процессыг хялбарчлах, иргэдийн санал гомдол, хяналт шалгалтын дүгнэлт болон Хүүхэд хамгааллын тухай хуулийг дагаж Нийгмийн халамжийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөд үндэслэн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулсан. Тогтоолын төслийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлэн, аймаг дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс санал авч саналыг тусган эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2025.11.12-ны өдрийн 01/3642 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. 2. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчлэлээр нийгмийн халамжийн сангаас олгож байгаа тэтгэмж, дэмжлэг, үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэх бодлогыг баримталж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээний шат дамжлагыг багасгаж, хүндрэл, чирэгдэлгүй болгох, хэрэгжилтийн явцад тулгамдаж байгаа зарим асуудлыг сайжруулах зорилгоор Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөнгөлөлт, тусламж үзүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулсан. Түүнчлэн Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийг шинэчлэн батлах тухай” 363 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ”-д нэмэлт оруулж, сонсголын аппаратын стандарт шаардлага, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн живх зэргийг нэмж 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын 248 дугаар тогтоолоор батлуулсан. Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/186 дугаар тушаалаар “Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн батлуулж, нийтээр дагаж мөрдөх захиргааны	
--	--	--	--	--	---	--

					хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 7388 дугаарт бүртгүүлсэн. Шинэчлэгдсэн журамд дараах зохицуулалтыг тусгасан: ✓ Өрхийн гишүүнээс хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай боловч хөдөлмөр эрхлээгүй гишүүнд үйлчилгээг олгохгүй; ✓ Хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхэлж байгаа гишүүнд хөдөлмөр эрхлэлтийг урамшуулах зорилгоор үйлчилгээг үзүүлэх; ✓ Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд олон жил хамрагдсан эсхүл өрхийн амьжиргааны түвшин дээшилсэн өрхийг хасаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах; ✓ Ядуу өрхүүдэд чиглэсэн өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж өрхтэй ажиллах, хүүхдүүдийг сургууль цэцэрлэгт хамруулах, эрүүл мэнд, боловсролын хөтөлбөрт хамруулах; ✓ Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн тэжээн тэтгэгч нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжгүй ганц бие харж хандах хүнгүй ахмад настанд түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүлэх; ✓ Хоол тэжээлийн дутмагшлын улмаас хүнд хэлбэрийн тураалтай хүүхэд болон гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг тус үйлчилгээнд хамруулах; ✓ Халамжаас хөдөлмөрт бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах зэрэг болно. Шинэчлэн баталсан энэхүү журмыг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 12 дугаар сарын байдлаар 14,334 хүнд 11,439,162.5 мянган төгрөг олгогдсон байна. 3. Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал, өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдаж буй	
--	--	--	--	--	--	--

					асуудлыг танилцуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцох уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтаар Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэл, мэдээллийн найдвартай байдал, захиргааны мэдээллийн шинэчлэлийг сайжруулах арга зам болон тус мэдээллийн санг ашиглан нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах зорилтот өрх, иргэнийг сонгох журам дүрмийг сайжруулахаар шийдвэрлэсэн. “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.11.27-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/162 дугаар тушаалаар байгуулан журмын төслийг боловсруулан ажиллаж байна. Мөн журмын төслийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж, ирүүлсэн саналыг журмын төсөлд тусган ажиллаж байна.	
1.3.Халамж, асрамжийн үйлчилгээний норматив зардал, жишиг үнийг нэмэгдүүлэх тооцоо судалгаа хийх, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулах	Батлагдсан баримт бичиг /тоо/ /1. Асаргааны өвчин гэмтлийн жагсаалт, 2.ОНОТХҮ, асрамжийн норматив, 3.Протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жишиг үнэ/	-	3	-	1.Засгийн газрын 2024 оны “Нийгмийн халамжийн тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох, тогтоол өөрчлөлт оруулах тухай” 247 дугаар тогтоолын хүрээнд Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн “Тушаалд нэмэлт оруулах тухай” А/68, А/62 дугаар тушаалаар “Байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур”-ыг баталсан. Уг тушаалын дагуу хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлон, халамжийн нэгдсэн системд зохих хөгжүүлэлтийг хийж, асаргааны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэн олгож байна. 2. Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт орж, уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэгт “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журам, үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар, аргачлал, заавар, үнэ тарифыг нийгмийн халамжийн асуудал	100

						эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журам батлах тухай” Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/35 дугаар тушаал баталсан. Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/53 дугаар тушаалаар Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний аргачлал, заавар, үйлчилгээний үнэ тариф, гэрээний загварыг баталсан. 3. Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийг шинэчлэн батлах тухай” 363 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ”-д нэмэлт оруулж, 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 248 дугаар Засгийн газрын тогтоолоор батлуулсан. Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.13-д ахмад настны төрөлжсөн үйлчилгээнд хамрагдаж байгаа нэг хүнд ногдох зардлын нормативыг байнгын асаргаа шаардлагатай иргэнд 3 дахин нэмэгдүүлэн тооцно гэсэн нэмэлт хэсэг тусгасан. Хуулийн нэмэлт, өөрчлөлт 2025 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор улс, орон нутгийн болон магадлан итгэмжлэгдсэн хувийн хэвшлийн асрамжийн газарт асруулж байгаа байнгын асаргаатай ахмад настны зардлын нормативыг 3 дахин нэмэгдүүлж тооцон 2026 оны төсвийн саналд тусгах боломжийг бүрдүүлсэн.	
Зорилт 2. Нийгмийн халамжийн үйлчилгээ,	2.1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн	Боловсруулсан баримт бичиг /тоо/	-	1	Улсын төсөв	❖ Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ний өдөр Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан бөгөөд уг хуулийг дагаж Нийгмийн халамжийн тухай хуульд	100

асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлж, хувийн хэвшил, орон нутаг, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх	үйлчилгээний аргачлал, заавар, шалгуур, журам, гэрээний загвар, үнэ тарифыг шинэчлэн батлуулах				нэмэлт, өөрчлөлт орсон. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дэргэдэх Магадлан итгэмжлэлийн зөвлөлөөс магадлан итгэмжилж, үйлчилгээ явуулах эрх олгодог байсан. Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт орж, уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэгт “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журам, үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар, аргачлал, заавар, үнэ тарифыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх аргачлал, заавар, үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, үйлчилгээ үзүүлэх журмыг хуульд орсон өөрчлөлтийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/35 дугаар тушаалаар баталсан. Энэ хүрээнд өмнө баталж мөрдүүлж байсан эрх зүйн баримт бичгүүд, түүний үйлчлэл зэргийг судалж шинээр боловсруулах журам, тавигдах шалгуурт нарийвчлан тусгаж, зохицуулалтын хувьд илүү ойлгомжтой, уян хатан, ил тод, нээлттэй байх, үйлчилгээг мэргэжлийн болгох, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах зэргийг анхааран эрх зүйн зохицуулалтыг хийв. ❖ Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх аргачлал, заавар, үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, үйлчилгээ үзүүлэх журмыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/35 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянаад захиргааны эрх зүйн хэм хэмжээний актын нэгдсэн сангийн 7156 дугаарт бүртгүүлэн ажилласан. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/53 дугаар тушаалаар “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний аргачлал, заавар, үйлчилгээний үнэ тариф, гэрээний загварыг баталсан.
--	--	--	--	--	---

	2.2.Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ асаргааны хувилбарт үйлчилгээг улсын хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах	Үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо	-	1	Улсын төсөв	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам” болон “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах журам”, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/51,37 дугаар хамтарсан тушаалаар “Үйлчилгээний жишиг үнэ, иргэний хариуцах төлбөрийн хэмжээ”-г тус тус баталсан. Дээрх журмуудын хүрээнд 2025 оноос эхлэн ахмад настны Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ болон асаргааны хувилбарт үйлчилгээг үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын сонгон шалгаруулалтыг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2025 оны 4 дүгээр сараас эхлэн зохион байгуулж, тэнцсэн байгууллагуудтай гэрээ байгуулан ажилласан байна. 2025 онд улсын хэмжээнд ахмад настны Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээг 37 байгууллага, харин өдрөөр болон гэрээр асрах үйлчилгээг 22 байгууллага, ахмад настныг байнга байрлуулан асрах үйлчилгээг 1 байгууллага нийт 60 байгууллага гэрээлэн гүйцэтгэв. Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээг харьцангуй эрүүл, бие даах чадвартай буюу цогц үнэлгээгээр 1 дүгээр түвшний ахмадуудад дараах чиглэлээр үзүүлж байна: • Лавлагаа мэдээлэл өгөх; • Дасгал хөдөлгөөн; • Эрүүл зөв хооллолт; • Төрөл бүрийн сургалт; • Сэтгэл зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх; • Сайн дурын ажил үйлчилгээ явуулах; • Бүжиг, иог зэрэг урлаг соёлын бусад арга хэмжээ. Асаргааны хувилбарт үйлчилгээнд ахмад настны цогц үнэлгээгээр 3 дугаар түвшний шаардлагатай бол 2 дугаар түвшинд үнэлэгдсэн	100
--	--	-------------------------------------	---	---	-------------	--	-----

					байнгын асаргаа сувилгаа шаардлагатай, бие даана амьдрах, өөрөө өөртөө үйлчилэх чадвар хязгаарлагдмал ахмад настнуудад дараах төрлөөр үзүүлж байна.Үүнд: • Өдрийн асаргаа • Гэрээр нь очиж үйлчилгээ үзүүлэх • Түр эсхүл урт хугацаагаар • Байнга асрах үйлчилгээ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын тайлангаар 2025 оны 12 дугаар сарын байдлаар Идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ болон асаргааны хувилбарт үйлчилгээнд нийт 21,482 ахмад настан хамрагдаж, үйлчилгээ үзүүлсэн байгууллагын гэрээний тайлан, хэрэгжилтэд үндэслэн 12 дугаар сарын гүйцэтгэлээр 2.2 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангаас олгосон байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс гэрээ байгуулсан 60 байгууллага, ажилтнуудад ахмадын үйлчилгээний холбогдох журмын талаар болон мэрэгжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулж ажиллав.	
2.3.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ шинээр үзүүлэх байгууллагад санхүүжилт олгох, сонгон шалгарсан байгууллагын мэдээллийн сан бүрдүүлэх	Дэмжлэгт хамрагдсан байгууллагын тоо	-	1	Улсын төсөв	УИХ-аас баталсан Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Хуулийн нэмэлт өөрчлөлтийг дагалдуулан Нийгмийн халамжийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хувийн хэвшлийн асрамжийн газрыг дэмжих зорилгоор төрөлжсөн асрамжийн үйлчилгээг шинээр үзүүлэх болон барилга байгууламж барих аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлэх журмыг баталж, мөрдүүлэхээр заасан. Үүний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 245 дугаар тогтоолоор "Ахмад настны асрамжийн үйлчилгээ шинээр үзүүлэх, барилга байгууламж барих аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлэх журам"-ыг батлан мөрдөж ажиллаж байна. Журмын дагуу дэмжлэгт хамрагдах асрамжийн байгууллагын хүсэлтийг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс хүлээн авч	100

					шалгуур хангаж байгаа тохиолдолд шаардагдах санхүүжилтийг төсвийн саналд тусгах юм. Мөн Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.13-т “Энэ хуулийн 19.5.1-д заасан нэг хүнд ногдох зардлын нормативыг байнгын асаргаа шаардлагатай иргэнд 3 дахин нэмэгдүүлэн тооцно.” гэсэн зүйл шинээр нэмж ахмадын асрамжийн газарт асруулж байгаа байнгын асаргаа сувилгаа шаардлагатай ахмад настны зардлын нормативыг нэмж тооцон санхүүжилт авах боломжийг бүрдүүлсэн. 2025 онд нийслэл хотод үйл ажиллагаа явуулдаг Батгэрэлт ирээдүй ТББ-ын харьяа асрамжийн газарт асруулагчдын зардлын нормативт 1,5 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангаас олгохоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар гэрээ байгуулан асрамжийн газруудын мэдээллийн санд бүртгэн ажиллаж байна.	
2.4.“Төгсөлтийн аргачлал” туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэх	Амьжиргаа дээшилсэн өрхийн хувь	71	80	Олон улсын байгууллага	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийг Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй буй “Цар тахлын үе хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2”-ын хүрээнд 2022 оны 7 дугаар сараас 2025 оны 8 дугаар сарыг дуустал буюу 36 сарын хугацаатайгаар хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд зорилтот өрхийн гишүүдийн зан үйл, хандлагыг өөрчлөх зөвлөгөө, сэтгэл зүйн засалд хамруулах, хэрэгцээтэй үйлчилгээнд холбон зуучлах, амьдрах ухаан, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах, бие даан амьдрах чадвар, дадлыг хэвшүүлэх зэргээр тухайн өрхийг чадавхжуулах, амьжиргааг дэмжихэд чиглэсэн олон арга хэмжээг авч хэрэгжүүлж, 11 төрлийн тоног төхөөрөмжийг 1256 өрхөд олгосон. Хөтөлбөрт хамрагдаж байгаа 1259 өрхийг улирал бүр үндсэн 10 шалгуур үзүүлэлтээр өрх тус бүрээр үнэлж хяналт тавьж ажилласан. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа 2025 дугаар 7 дугаар сарын 2-ны өдрөөр дуусгавар болсон бөгөөд хөтөлбөрт хамрагдсан нийт өрхийн 80.6 хувь өрх төгсөх шалгуурыг хангаж амжилттай төгссөн болно. Энэхүү аргачлалыг улсын хэмжээнд нэвтрүүлэхээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны	100

					12 дугаар сарын 03-ны өдрийн 01/3923 тоот албан бичгээр аймаг, нийслэлийн Засаг даргад хамтран ажиллах чиглэлийг хүргүүлсэн. Цаашид 2026-2028 онд зорилтот 5000 өрхийн амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөрийг хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	
	2.5.Зорилтот бүлгийн иргэдийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээг шинэчлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн хувь	-	10	Олон улсын байгууллага Зорилтот бүлгийн иргэдийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээг шинэчлэх хүрээнд Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт орж, уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэгт “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журам, үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар, аргачлал, заавар, үнэ тарифыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх аргачлал, заавар, үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, үйлчилгээ үзүүлэх журмыг хуульд орсон өөрчлөлтийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/35 дугаар тушаалаар баталсан. Уг тушаалын хүрээнд өмнө нь хэрэгжиж байсан “нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах” үйлчилгээг шинэчлэн өрхийг хөгжүүлэх замаар бие даан амьдрах, тогтвортой амьжиргаанд шилжүүлэх урт хугацааны үйлчилгээг тодорхойлон хэрэгжүүлж байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан зорилтыг хэрэгжүүлэх, халамжаас-хөдөлмөрт бодлогын хүрээнд зорилтот өрхийн гишүүдийг чадавхжуулах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор олон улсад туршигдаж, үр дүнд хүрсэн “Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөр”-ийг Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр	30

						2022-2025 онд нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүрэгт тус тус хэрэгжүүлсэн. Уг туршилтын хөтөлбөрийн загварыг ашиглан “Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр боловсруулан, уг хөтөлбөрт хамрагдах өрхийн тоог аймаг, дүүргээр гаргаж Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Уг хөтөлбөрт нийт зорилтот 5000 өрхийг хамруулж, хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулах замаар өрх, иргэний амьжиргааг дээшлүүлэх зорилготой хэрэгжүүлэх юм.	
Зорилт 3. Нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	3.1.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх	Нэмэгдлийн хувь	-	6	Улсын төсөв	Нийгмийн халамжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг тухайн үед мөрдөж байгаа хүн амын амьжиргааны доод түвшингийн хэмжээг үндэслэн Засгийн газар тогтооно.” гэж заасан. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн дагуу батлагдсан төсөвт багтаан хөгжлийн бэрхшээлтэй хүний тэтгэвэр, тэтгэмжийг 20 хувиар, бусад тэтгэвэр, тэтгэмжийг 8.6 хувиар нэмэгдүүлэхээр Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж хүргүүлсэн. Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор батлуулсан.	100
	3.2.Нийгмийн халамжийн хүний нөөцийг чадавхыг бэхжүүлэх, сургалтын платформыг ашиглан салбарын ажилтан, албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулах	Онлайн сургалтын платформ ашиглан зохион байгуулсан сургалтын тоо	-	2	Улсын төсөв	Нийгмийн халамжийн салбарын албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх, мэргэжил, арга зүйгээр хангах, алсын зайнаас сургах surgalt.hudulmur-halamj.gov.mn цахим платформыг ашиглалтад оруулж, салбарын 1500 орчим албан хаагчдыг шинэчлэн бүртгэсэн. Ингэснээр сургалтыг орон зай үл хамааран тасралтгүй зохион байгуулах боломжтой болсон ба цахим системд хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж болон нийгмийн ажлын арга зүй, төрийн албан хаагчын ёс зүй гэх мэт бусад чиглэлээр 54 хичээлийг дэд бүлэгтэйгээр байршуулаад байна. Цаашид төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сертификат олгох сургалтыг шат дараалан оруулахаар төлөвлөн ажиллаж байна.	100

					Мөн нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд хүндрэл бэрхшээлгүйгээр нэгдсэн нэг ойлголттойгоор хүргэх чиг үүргийн хүрээнд: -Тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой 5 удаагийн чиглэл, 3 удаагийн цахим сургалт, -Ахмад настны тухай хууль, шинээр батлагдсан журмын хүрээнд 7 удаагийн цахим сургалт зохион байгуулж, хэрэгжилтийг хангах 6 удаагийн зөвлөмж, чиглэл -Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан 2 удаагийн албан чиглэлийг хүргүүлж, цахим системээр 3 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг -Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чиглэлээр 5 удаагийн сургалт, 9 удаагийн чиглэлийг хүргүүлэн ажилласан. Нийт 18 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж, 22 удаагийн зөвлөмж, чиглэлийг хүргүүлж тухай бүр мэдээлэл хүргэн ажиллаж байна.	
3.3.Халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн болон ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг үнэлэх сэтгэл ханамжийн судалгааг хагас жил тутамд цаасан болон цахим (киоск, мессеж) хэлбэрээр үнэлэх, аймаг, дүүрэг тус бүрээр нэгтгэн үнэлгээг гаргах, үр дүнд үндэслэн үйлчилгээг сайжруулах	Иргэдийн сэтгэл ханамжийн өсөлтийн хувь /аймаг, дүүргээр, улсын хэмжээнд/	-	1	Улсын төсөв	Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээний киоскыг байршуулан ажиллуулж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн халамжийн үйлчилгээнд шинээр 183,648 иргэнийг хамруулж ажилласны 43027 нь тус киоскоор дамжуулан халамжийн үйлчилгээг үнэлсэн байна. Халамжийн үйлчилгээг үнэлсэн нийт иргэдийн 40497 буюу 94,1 хувь нь халамжийн байгууллагаас үзүүлсэн үйлчилгээнд сэтгэл хангалуун буюу маш сайн, сайн гэж үнэлсэн бөгөөд иргэн 1-5 (Маш муу - Маш сайн) онооны хооронд үнэлгээ өгсөн ба үнэлгээний дунджаар 4.7 үнэлгээтэй байна. Нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд хүндрэл бэрхшээлгүйгээр хүргэх чиг үүргийн хүрээнд нийгмийн халамжийн хууль эрх зүйн шинэчлэл, программ хангамжийн хөгжүүлэлт зэргийн талаар аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хэлтсийн холбогдох албан тушаалтнуудад ойлголт өгөх 3 удаагийн цахим болон танхимын сургалт арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 100 гаруй албан тушаалтнуудыг хамруулсан байна.	100

						Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламж олгох, шинээр батлагдсан хууль эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлэх болон нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах, чиглэлээр 22 удаагийн зөвлөмж, чиглэлийг аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүргүүлж ажилласан.	
3.4.Нийгмийн халамжийн үйлчилгээ, олголтод төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт зохион байгуулах / Протез, ортопед, тусгай хэрэгсэл, амралт, сувилал г.м/	Зохион байгуулсан хяналт, шалгалтын тоо	-	1	Улсын төсөв	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 243 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох журам”-ын 8.5-д Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь ахмад настанд олгосон протез, ортопед, тусгай хэрэгслийн чанар, үйлчилгээнд хөндлөнгийн болон олон нийтийн хяналт, шалгалтыг жилд нэг удаа зохион байгуулж ажиллахаар заасны дагуу протез, ортопед, тусгай хэрэгслийн чанар, үйлчилгээнд хөндлөнгийн болон олон нийтийн хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж ажиллах тухай 04/1879 дугаартай чиглэлийг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүргүүлж ажилласан. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу протез, ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлтөд хамрагдсан ахмад настанаас түүврийн аргаар сонгон 2,730 ахмад настанаас утсаар болон гэрээр нь зочилж ашиглаж буй протез, ортопед, тусгай хэрэгсэл тухайн ахмад настны хэрэгцээ болон чанарын шаардлага хангаж байгаа эсэх судалгааг авч нэгтгэсэн. Мөн протез, ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлдэг 99 байгууллагын үйл ажиллагаанд хяналт хийж, зөрчил дутагдал гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж өгч, батлагдсан хууль журмын талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.	100	
					Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэний асаргааны тэтгэмжид хяналт шалгалт хийх ажлыг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн		

					үйлчилгээний газар, хэлтэст байгуулагдсан ажлын хэсгээр дамжуулан зохион байгууллаа. Хяналт шалгалтаар байнгын асаргаа шаардлагатай 71,775 иргэний 32.9 хувь буюу 23,658 иргэний цахим болон цаасан хувийн хэрэгт хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэхэд 1,752 иргэний тухайд батлагдсан өвчин гэмтлийн жагсаалттай нийцээгүй өвчний оноштой, өвчин гэмтлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, хувийн хэргийн бүрдэл дутуу зэрэг зөрчил дутагдал илэрсэн. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст дээрх иргэдийн үйлчилгээг түр түтгэлзүүлж, зөрчлийг арилгах, цаашид дотоод хяналт шалгалтыг эрчимжүүлэх чиглэл зөвлөмжийг өгч, хяналт шалгалтын ажлын үр дүнгийн тайлан, үйлчилгээг үзүүлэхэд тулгарч байгаа хүндрэл бэрхшээл шийдвэрлэх арга замын талаар санал, дүгнэлтийг боловсруулсан. Хяналт шалгалтын үр дүнд үндэслэн байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэний өвчин гэмтлийн жагсаалтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг тус яаман дээр байгуулан ажиллаж байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/133 дугаар тушаалаар баталсан “Үзлэг шалгалт хийх тухай” удирдамж, асуумж судалгааны дагуу асрамжийн газруудад хийгдсэн үзлэг шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчил дутагдлыг арилгах ажлын төлөвлөгөөг Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газрын даргаар батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлдэг 12 асрамжийн газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 04/127 дугаартай албан бичгээр илэрсэн нийтлэг зөрчил дутагдлыг арилгах чиглэл хүргүүлж ажилласан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу Ахмад настны үндэсний төв, Баян-өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Ахмад настны асрамжийн газар, Батгэрэлт-ирээдүй ТББ-ын дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй иргэний төрөлжсөн асрамжийн	
--	--	--	--	--	---	--

						газруудын үйл ажиллагаатай танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	
Нийгмийн даатгалын бодлого							
Үндсэн чиг үүрэг 1: Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлого							
Зорилт 1. Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн, эрх зүйн орчинг боловсронгуй болгох	1.1.Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /тоо/	Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийг баталсан. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлээд байна.	1	Улсын төсөв	Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тус тус боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/1783, 01/1778 дугаар албан бичгээр Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлснээр Хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг хамтран баталсан. Хуулийн төслийг боловсруулах хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, Хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайлан болон хуулийн төслүүдийг тус тус боловсруулсан. Хуулийн төслүүдийг Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон. Харин Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанд дахин хэлэлцүүлсэн бөгөөд Засгийн гишүүдийн гаргасан саналын дагуу хуулийн төслийг хэлэлцэхийг хойшлуулаад байна.	90
Зорилт 2. Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настууд олон	2.1.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /тоо/	-	1	Улсын төсөв	Тэтгэврийн олон давхаргат тогтолцоонд шилжих, тэтгэвэр авагч олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой болох зорилтын хүрээнд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/48 дугаар тушаалаар байгуулан ажиллаж, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай анхдагч хуулийн төсөл, хуулийг дагаж өргөн мэдүүлэх 13 хуулийн төсөл болон холбогдох тооцоо судалгааг тус тус боловсруулсан.	90

эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлэх						Хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 06 сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Харин Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан хуулийн төслүүдийг Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанд дахин хэлэлцүүлсэн бөгөөд Засгийн гишүүдийн гаргасан саналын дагуу хуулийн төслийг хэлэлцэхийг хойшлуулсан. Дээрх шийдвэрийг дагуу Хууль тогтоомжийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Хувийн нэмэлт тэтгэврийн хухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлахаар 2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 01/3077 дугаар албан бичгээр хүргүүлж, санал авсан. Яамдаас ирүүлсэн саналыг тусган Үзэл баримтлалын төслийг хамтран батлахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/3494 дүгээр, Сангийн яаманд 2025.12.03-ны өдрийн 01/3911 дугаар албан бичгээр тус тус дахин хүргүүлээд байна. Түүнчлэн, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанд танилцуулсан бөгөөд Хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад даалгасан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.	
Зорилт 4. Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.	4.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг жил бүр инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх	Нийгмийн даатгалын тэтгэврийн нэмэгдэл, хувиар	2024 онд 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж бүрэн тэтгэвэр 650.0, хувь тэнцүүлсэн	6	Улсын төсөв	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлэхээр заасан. Энэ хүрээнд Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 221 дүгээр тогтоолоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 6 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Энэхүү арга хэмжээнд нийт 505.6 мянган	100

			тэтгэвэр доод хэмжээ 540.0 мянган төгрөг.			тэтгэвэр авагч хамрагдаж, тэтгэврийн нэмэгдэлд 300.0 тэрбум төгрөг зарцуулсан. Ингэснээр дундаж тэтгэврийн хэмжээ 859.5 мянга, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689.0 мянга, хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээ 572.4 мянган төгрөгт тус тус хүрсэн. Түүнчлэн, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэхэд шаардагдах 477.9 тэрбум төгрөгийг баталсан. Энэ хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 80.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх тооцоолол хийн “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 242 дугаар тогтоолыг батлуулсан.Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээг 769,000 төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн олгосон тэтгэврийн доод хэмжээг 652,400 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон.	
4.2.Иргэд, даатгуулагч, ажил олгогч болон нийгмийн даатгалын харилцаанд оролцогч бусад талуудын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, эерэг хандлагыг төлөвшүүлэх замаар нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан хувь	80.9	81.1	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/174, А/175 дүгээр тушаалын дагуу нийгмийн даатгалын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. • Нийгмийн даатгалын салбарын чиглэлээр хууль тогтоомж, дүрэм, журам, заавар болон статистик мэдээллийг ГБХНХЯ-ны www.mlsp.gov.mn хуудас болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын www.ndaatgal.mn цахим хуудаст тухай бүр байршуулж ажил олгогч, иргэд, олон нийтэд хүргэж байна. https://mlsp.gov.mn/content/detail/3137 • Түүнчлэн, тайлант хугацаанд нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчлэх хүрээнд олон нийтээс санал авахаар “Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, “Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай	100	

					хуулийн төсөл, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус яамны вэбсайтын “Хууль эрх зүй” хэсэгт байршуулан олон нийтээс санал авч хэлэлцүүлсэн. https://mlsp.gov.mn/content?c=5 Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ авах явцад иргэд, даатгуулагч, ажил олгогчдод тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, сайжруулж, гарч буй асуудал, хүндрэлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор SICOS систем https://portal.ndaatgal.mn/ цахим хуудсаар дамжуулан цахим судалгааг 2025 онд зохион байгуулсан. Судалгааг иргэд, даатгуулагчаас нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар авах боломж, тэтгэмжийн цахим үйлчилгээ, цахим системийн ашиглалт талаар 4 асуулт, мөн ажил олгогчдоос цахим системээр тайлан илгээх, мэдээлэл оруулах, системийн ашиглалт сайжруулалтын талаар нийт 9 асуултын хүрээнд авсан бөгөөд 3,201 иргэн, 1,718 ажил олгогч хамрагдсан байна. Судалгаанд оролцсон иргэд, даатгуулагчдын тухайд нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаарх сэтгэл ханамж, үйлчилгээ авах, хэрэглэх явцад хүндрэл, тулгамдаж буй байгаа талаар илэрхийлсэн. Тухайлбал: “Даатгуулагч та нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар бүрэн авч чадаж байна уу?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 73% нь тийм гэж хариулсан бол 27% нь үгүй гэж хариулсан байна. “Нийгмийн даатгалын тэтгэмжийн үйлчилгээ авахад ямар нэг бэрхшээл гардаг уу?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 63% нь үгүй, 37% нь тийм гэж хариулсан байна. Ажил олгогчдын тухайд шимтгэлийн тайлан илгээх, мэдээлэл оруулах, цахим системийн ашиглалтын талаар дийлэнх нь хангалттай сайн гэж үнэлсэн байна. Тухайлбал: “Нийгмийн даатгалын тайлангаа боловсруулж илгээхэд хялбар ойлгомжтой байна уу?” гэсэн асуултад нийт	
--	--	--	--	--	--	--

					1,718 оролцогчдын 89% нь тийм, 11% нь үгүй гэж, мөн 70% нь шимтгэл төлөгчөөр бүртгүүлэхэд хүндрэлгүй, 79% нь цахим системд ажилтан шинээр нэмэхэд хялбар ойлгомжтой, 21% нь бэрхшээлтэй гэж хариулжээ. Мөн цаашид цахим системийн гацалт, ачаалал даах чадвар, хурдыг сайжруулах, хэрэглэгчийн хэрэглэх зааврыг хялбаршуулан тайлбарыг системд байршуулах, өмнөх мэдээллийг харах боломжийг бүрдүүлэх, тайланг Excel форматаар боловсруулах боломжийг бүрдүүлэх зэрэг асуудлыг анхаарах шаардлагатай гэжээ. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь 2025 оны А/130 дугаар тушаалаар Ажлын хэсгийг байгуулан тус судалгааны үр дүн болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газартай хамтран нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэнтэй холбогдуулан програм хангамжид гарч байгаа алдааг засах, хөгжүүлэлт, сайжруулалт хийх тогтворжуулах, бодлогын даалгавар боловсруулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, SICOS системийг сайжруулж ажилласан. Нийгмийн даатгалд 2024 онд 1,136.9 мянган даатгуулагч хамрагдсан нь Монгол Улсын нийт ажиллах хүч (1,441.1 мянга)-ний 79 хувийг эзэлж байна. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын статистик мэдээгээр 1,350.6 мянган хүн нийгмийн даатгалд хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 1.3 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. 2025 оны жилийн эцсийн статистик тайлангаар нийт даатгуулагчийн тоог давхардалгүйгээр тооцоолон гаргадаг бөгөөд ингэснээр тухайн оны ажиллах хүч болон даатгуулагчийн харьцааг гаргах боломжтой.	
4.3.Нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон	Цахимжуулсан үйлчилгээ, өссөн дүнгээр	24	26	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	• Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/101 тушаалаар нийгмийн даатгалын үйлчилгээг их өгөгдөлд үндэслэн иргэдэд цахимаар үзүүлэх бэлтгэл ажлыг хангах Ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, “Үндэсний дата төв” УТҮГ, “И-Монгол академи” УТҮГ, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн	100

	зайнаас хамааран нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах	үл авах				үйлчилгээний ерөнхий газрын төлөөллийг оролцуулан байгуулан ажилласан. Түүнчлэн, нийгмийн даатгалын SICOS мэдээллийн системийн хөгжүүлэлт хийгдсэнээр хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг 2025 оны 10 дугаар сарын 01-нээс эхлэн цахимаар авч эхэлсэн. - Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлэх үйл ажиллагааг нийгмийн даатгалын SICOS программд холбож, иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадалсан шийдвэрийг цахимжуулсан. Ингэснээр эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд даатгуулагч, хүнийг ирүүлэхгүйгээр хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих асуудлыг цахимаар бүрэн шийдвэрлэх нөхцөл бүрдсэн. - Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалт тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих, хөгжлийн бэрхшээлтэй хүний байнгын асаргааг тодорхойлох, сэргээн засах, сувилал, эмнэлгийн хуудас олгох, хяналт хийхэд шаардлагатай мэдээллийг санамсаргүй түүврийн аргад үндэслэн бүс хооронд цахимаар солилцох, шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх ажлыг Эрүүл мэндийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран зохион байгуулж байна. Энэ хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А125/А/212 дугаар “Мэдээлэл солилцох тухай” хамтарсан тушаалыг баталсан. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын байгууллага хооронд мэдээллийг цахимаар солилцох боломжийг бүрдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, И-монгол академитай хамтран Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас “WS300187_HealthInsuranceServiceLookup-Эрүүл мэндийн даатгалаар авсан тусламж, үйлчилгээний	
--	---	------------	--	--	--	--	--

						лавлах сервис"-ийг авч, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээлэл технологийн төвд хүргүүлсэн бөгөөд тус Төвөөс сервисийг хүлээн авч, нэвтрүүлэх хөгжүүлэлтийг хийж байна.	
Зорилт 5. Үндэсний баялгийн сангийн хуримтлалын сангаар дамжуулан эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	5.1.Шинээр төрсөн болон Монгол Улсын харьяат болсон, харьяатаа сэргээсэн иргэдэд хуримтлалын нэрийн данс нээх	Хуримтлалын нэрийн данс шинээр нээсэн иргэний тоо, мян.хүн	Монгол Улсын нийт 3,565.9 мянган иргэнд хуримтлалын нэрийн дансны бүртгэл үүсгэсэн.	56.5	Улсын төсөв	"Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журам"-ыг хэрэгжилтийг хангаж Монгол Улсын нийт 3,565.9 мянган иргэний хуримтлалын нэрийн дансанд 138.9 мянган төгрөгийн бүртгэл үүсгэсэн. Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар Хуримтлалын санд 2025 оны эхний хагас жилийн байдлаар төвлөрсөн мөнгөн хөрөнгийг иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд хуваарилан бүртгэхээр шийдвэрлэж иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансны үлдэгдэл 175.4 мянган төгрөг болсон.	100
	5.2. Үндэсний баялгийн сангаар дамжуулж хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд хөрөнгө хуримтлуулах	Хуримтлуулсан хөрөнгийн хэмжээ	499,529.2	507,114.8	Бусад эх үүсвэр	Хуримтлалын сангийн нийт мөнгөн хөрөнгө 954.4 тэрбум төгрөг болоод байна. Үүнд: Хуримтлалын сангийн 2024, 2025 оны ногдол ашиг 907.3 тэрбум төгрөг, хүүгийн орлого 46.7 тэрбум төгрөг, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2024 оны 2, 3 дугаар ээлжийн энгийн хувьцааны ногдол ашгаа Хуримтлалын нэрийн дансандаа шилжүүлэх хүсэлт гаргасан 4026 иргэдийн 342.6 сая төгрөгийн ногдол ашиг тус тус төвлөрсөн байна. Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар Хуримтлалын санд уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгаас 507.1 тэрбум төгрөг, хүүгийн орлогоор 55.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр, Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 562.1 тэрбум төгрөг байхаар тус тус хуульчилсан. Энэхүү эх үүсвэрийг төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрийг санхүүжүүлэх хэлбэрээр санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулж, арвижуулах, арга хэмжээ авч холбогдох гэрээ байгуулах эрх олгох агуулга бүхий Засгийн газрын 2025.05.07-ны өдрийн "Хууль хэрэгжүүлэхтэй	100

					холбогдуулан авах арга хэмжээний тухай” 228 дугаар тогтоолыг батлуулсан. Засгийн газрын 2025.02.05-ны өдрийн “Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн хөрөнгийн удирдлагын бодлого батлах тухай” 72 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагыг бодлого”-ын 3.1-т “Сангийн хөрөнгийн удирдлагыг Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.3-т заасны дагуу Монголбанк Засгийн газартай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, нөгөө талаас Монголбанк хооронд 2025.06.02-ний өдрийн 98,А/132,2025/195,0525/183 дугаартай “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах ерөнхий гэрээ”-г байгуулсан. Тус гэрээний дагуу Монголбанк 2024 онд Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгөнөөс 480.2 тэрбум төгрөгийг арилжааны 9 банкаар дамжуулан орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн эх үүсвэрт хөрөнгө оруулсан бөгөөд уг эх үүсвэрээр ипотекийн зээлд 4,158 өрх хамрагдсан. Харин 2025 онд Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгөөс төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн санхүүжитэд 374.2 тэрбум төгрөг шилжүүлснээс 360.3 тэрбум төгрөгийн зээл олгогдоод байна. Харин Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулиар Хуримтлалын санд 372,901.0 сая төгрөг, хүүгийн орлогоор 156,028.9 сая төгрөг төвлөрүүлэхээр, нийт 528,929.9 сая төгрөгөөр хуримтлуулахаар тус тус баталсан.	
5.3. Иргэн бүрт хуримтлалын нэрийн дансны мэдээллийг “И-Монгол” платформоор	Иргэний хуримтлалын нэрийн дансанд тухайн жилийн ногдол ашиг, хүүгийн орлогыг	Хуримтлалын нэрийн дансанд 2024 оны ногдол ашгийг	Тухай бүр	Бусад эх үүсвэр	Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын нийт 3,565.9 мянган иргэнд хуримтлалын нэрийн данс үүсгэн Хуримтлалын санд 2024 он, 2025 оны эхний хагас жилд төвлөрсөн мөнгөн хөрөнгийг хуваарилан бүртгэж, иргэн бүрд 175.4 мянган төгрөгийн хуримтлал бий болоод байна.	100

	дамжуулан харуулах	хуваарилж, харуулах	хуваарилан "И-Монгол" платформоор дамжуулан харуулсан.			Мөн "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны 2, 3 дахь удаагийн ногдол ашгийг Хуримтлалын сангийн хуримтлалын нэрийн дансандаа хуримтлуулах саналыг "И-Монголиа" цахим системээр дамжуулан гаргасан иргэдийн ногдол ашгийг Монголбанкн дах Төрийн сангийн Үндэсний баялгийн сан (Хуримтлалын сан) шилжүүлэх зохицуулалтыг тусгасан "Хуримтлалын сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2025.04.09-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлуулж хэрэгжилтийг ханган 4026 иргэний нийт 342,566,151.45 /53,480,907.91 төгрөг, 289,085,243.54 төгрөг/ төгрөгийн санхүүжилтийг Хуримтлалын сангийн Монголбанкн дахь Төрийн сангийн 010164002141 тоот дансанд 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр шилжүүлсэн бөгөөд эдгээр иргэдийн хуримтлалын нэрийн дансанд тус орлогыг нэмж бүртгэсэн. Иргэн төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монгол системийн Профайл цэсийн "Чингис Хаан" Үндэсний Баялгийн сан хэсгээс иргэн өөрийн нэрийн дансны үлдэгдлийг харах нөхцөлийг бүрдүүлсэн.	
Ерөнхий чиг үүрэг: Өгөгдөл/ мэдээллийн							
Үндсэн чиг үүрэг: Салбарын цахимжилт, мэдээллийн технологи							
Зорилт 1.Цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, өгөгдөлд суурилсан шийдлүүд нэвтрүүлэх	1.1.Салбарын цахим шилжилтийг дэмжих, цахим үйлчилгээг нэмэгдүүлэх, хүртээмжтэй болгох.	Сайжруулалт хийсэн цахим үйлчилгээний тоо өссөн дүнгээр	79	82	Улсын төсөв, бусад эх үүсвэр	Судалгаа ба Төлөвлөлт: Салбарын цахим шилжилтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, дараах системийн хөгжүүлэлтийн Ажлын даалгавар (ToR)-ыг боловсруулан батлууллаа: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-н дэд систем; eJob системийн сайжруулалт eFamily үйлчилгээний систем; Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн сан; Хуримтлалын нэгдсэн сангийн систем; Мэдээллийн аюулгүй байдлын техникийн шинэчлэл. Систем хөгжүүлэлт ба сайжруулалт: eJob систем: "Дижиталворкс" ХХК-тай гэрээ байгуулан хөгжүүлэлтийг эхлүүлэв. Системийг төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбож, хэрэглэгчийн интерфейс (UI/UX) болон нэмэлт модулиудыг сайжруулах ажил хийгдэж байна.	
		Үйлчилгээ авсан хүний тоо өссөн дүнгээр	?	300,000	Улсын төсөв, бусад эх үүсвэр		90

					Хуримтлалын нэгдсэн сан: Системийн хөгжүүлэлтийг хийж, иргэд Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia)-ээс хуримтлалын мэдээллээ шууд харах боломжийг бүрдүүллээ. Мөн үндсэн системтэй мэдээлэл солилцох гэрээг байгуулан нийт 7 сервисийг тус системд ашиглаж байна. Үйлчилгээний процессын инженеринг: Протез, ортопедийн үйлчилгээ: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үзүүлэх процессыг хялбаршуулж зураглав. Шинэ шийдлээр ehalamj.mn системд эмч нарын хандах эрхийг үүсгэснээр иргэн үйлчилгээ авах эрхтэй эсэхийг үйлдвэр дээрээс шууд шалгах боломжтой болсон. Ингэснээр зөвшөөрөл авах шат дамжлага, хугацааг эрс бууруулав. Цаашдын зорилт: eBarimt системийн шийдэлд тулгуурлан иргэнээс шаарддаг цаасан баримтын тоог бууруулахаар ажиллаж байна. Салбарын хэмжээнд иргэдэд цахим үйлчилгээг дараах байдлаар үзүүлсэн байна. Үүнд: Халамжийн нэгдсэн систем болон E-Mongolia системээр дамжуулж 2025 оны байдлаар давхардсан тоогоор 629,587 иргэн хүсэлт гаргасан бөгөөд 381,349 иргэний үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч үйлчилгээ үзүүлсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн систем /ejob/-ийн https://ejob.gov.mn порталаар буюу цахимаар 2025 онд үйлчилгээ авсан 19,982 ажил хайгч иргэн байгаа бөгөөд үүнээс ажилгүйдлийн тэтгэмж авах зорилгоор бүртгүүлсэн 3,666 иргэн байна. Мөн 1,217 ажил олгогч цахимаар үйлчилгээ авч 43,399 орон тоо бүхий ажлын байрыг хөдөлмөрийн зах зээлд нээлттэй зарласан байна. Гадаадаас ажиллах хүч авах үйлчилгээний зөвшөөрөл олгох цахим систем /avah.hudulmur-halamj.gov.mn/ -ээр дамжуулан гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах зорилгоор 25,507 аж ахуйн нэгж байгууллага цахимаар хүсэлт гаргасан бөгөөд дээрх байгууллагууд нь 82 орны 126,777 гадаад иргэдэд зориулан урилга, зөвшөөрөл, сунгалт, хасалт зэрэг үйлчилгээний хүсэлтийг цахимаар хүлээн авч, үйлчилгээ үзүүлсэн байна	
--	--	--	--	--	--	--

					Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн систем (Sicos)-ээр 259.2 мянган, Portal.ndaatgal.mn системээр 216.2 мянган, нийт 475.5 мянган тэтгэвэр, тэтгэмжийн болон сайн дураар даатгуулах үйлчилгээ авах хүсэлт, мөн сар бүр 61.9 мянган ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн байна.	
1.2.Салбарын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн нууцлалыг хамгаалах тогтолцоог болгох.	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах баримт бичгийн тоо	-	2	Улсын төсөв, бусад эх үүсвэр	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмын төслийг боловсруулсан. Мөн МАБ-ыг сайжруулах хүрээнд системийн аудит хийх болон зарим журмыг боловсруулах тодорхойлолтыг боловсруулан батлуулсан байсан боловч 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан Төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр тухайн арга хэмжээний санхүүжилт хасагдсан тул хэрэгжих боломжгүй болсон.	90
	Кибер аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хийлгэсэн байгууллагын тоо	1	2	Улсын төсөв, бусад эх үүсвэр	Мэдээллийн аюулгүй байдлын газар (МАБГ)-аас яам, ХХҮЕГ-т тус тус кибер аюулгүй байдлын иж бүрэн эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Үнэлгээ нь бодлого, дүрэм, систем, сүлжээ, серверийн өрөөний аюулгүй байдлын хүрээнд хийгдсэн. Үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн дагуу эрсдэл бууруулах төлөвлөгөөг боловсруулан, илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлсэн. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг Мэдээллийн аюулгүй байдлын газарт хүргүүлсэн.	
	МАБ-ын аудит хийлгэсэн системийн тоо	1	2		МАБ-ыг сайжруулах хүрээнд сургалт болон нэг системд аудит хийх техникийн тодорхойлолтыг боловсруулан батлуулсан байсан боловч 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан Төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр тухайн арга хэмжээний санхүүжилт хасагдсан тул Мэдээллийн аюулгүй байдлын сургалт болон системийн аудит хийгдээгүй, хэрэгжих боломжгүй болсон.	
1.3.Салбарын ажилтнуудын цахим болон мэдээллийн технологийн ур чадварыг	Зохион байгуулсан сургалтын тоо	-	1	Улсын төсөв, бусад эх үүсвэр	“И-МОНГОЛ АКАДЕМИ” УТҮГ-аас Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 2025 онд зохион байгуулахаар төлөвлөж байгаа талаар албан бичиг ирүүлсний дагуу манай байгууллагаас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон харьяа агентлаг, байгууллагын албан хаагчдын цахим	70

	дээшлүүлэх, мэргэшүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.					ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах саналыг 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 03/83 тоот албан бичгээр хүргүүлсэн.Сургалт 2025 оны 05, 06 дугаар сард ГБХНХЯ, 4 агентлаг, 2 төвийн хэмжээнд зохион байгуулагдсан.	
		Сургалтанд хамрагдсан албан хаагчдын тоо	-	1000	Улсын төсөв, бусад эх үүсвэр	Сургалтад нийт 400 гаруй албан хаагч хамрагдсан.	
	1.4.Салбарын үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан (AI) болон бусад дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, турших, үр ашгийг нэмэгдүүлэх.	Хиймэл оюунд суурилсан үйлчилгээний тоо	-	2	Улсын төсөв, бусад эх үүсвэр	Хиймэл оюун нэвтрүүлэх үйлчилгээний нөхцөл байдлын үнэлгээ, бизнес процессын шинжилгээг хийж ажлын даалгаврыг боловсруулж нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн. 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр батлагдсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар тухайн арга хэмжээний санхүүжилт хасагдсан тул хэрэгжүүлэх боломжгүй болсон.	ҮБ
		Хиймэл оюун үйл ажиллагаандаа ашиглаж байгаа байцаагч/албан хаагчийн тоо	-	100	Улсын төсөв, бусад эх үүсвэр		
	1.5.Салбарын цахим мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулах, өргөтгөх, шинэчлэх.	Тооцоолох хүчний хэмжээ	23	375core	Улсын төсөв, бусад эх үүсвэр	Салбарын их өгөгдлийг бий болгоход шаардагдах тоног төхөөрөмжийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны журмын дагуу худалдан авалтыг зохион байгуулан худалдан авсан. Тухайн тоног төхөөрөмжүүдийг байршуулах гэрээг Үндэсний дата төвтэй 2025 оны 10-р сард гэрээ байгуулан суурилуулаад байна. Ингэснээр салбарын системүүдийг байршуулах, хэвийн найдвартай ажиллагааг хангахад серверийн хүчин чадал CPU:352 core, RAM:37TB, Storage: 510TB-аар тус тус нэмэгдэж байна.	100
		Санах ойн хэмжээ	768GB	37.7TB	Улсын төсөв, бусад эх үүсвэр		
		Хадгалах төхөөрөмжийн багтаамж	138TB	568TB	Улсын төсөв, бусад эх үүсвэр		
	1.6.Салбарын мэдээллийн технологийн хөгжилд хувийн	Сайжруулсан үйлчилгээний тоо	-	1	Улсын төсөв, бусад	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн дэд системийг бий болгож ажлын хүрээнд ажлын даалгаврыг боловсруулах үйлчилгээний ажлын даалгаврыг Төрийн нарийн бичгийн даргаар	50

	хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх.				эх үүсвэр	батлуулсан. 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр батлагдсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар тухайн арга хэмжээний санхүүжилт хасагдсан тул тус арга хэмжээг улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх боломжгүй болсон тул төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд дэд систем шинээр нэвтрүүлэхээр ажиллаж байна. Хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр систем хөгжүүлэлт хийж байгаа Акурр шийдэл ХХК-тай уулзалт зохион байгуулж холбогдох талуудын оролцоог хангаж системийн шийдлийн талаар танилцаж санал солилцсон. ХАБЭА тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд мэдээллийн системтэй холбоотой заалтуудыг тусган ХАБЭМТөв системийн суурь судалгаа болон ажлын даалгаврын төслийг боловсруулсан. ҮОХХ-н бүртгэл мэдээллийн системийг /www.om.inspection.gov.mn/ хүлээж авах ажлын хэсэгт ажиллан холбогдох саналуудыг өгч сайжруулалтыг гүйцэтгэгчээр хийлгэж системийг хүлээж комиссын акт гарсан.	
	1.8.Салбарын цахим мэдээллийн технологийн хөгжлийн үр нөлөөг үнэлэх, хянах, сайжруулах тогтолцоог бүрдүүлэх.	Салбарын үндсэн үзүүлэлтийг бүхий үр нөлөөний үзүүлэлтийг харуулах дашбордын тоо	-	2	Улсын төсөв, бусад эх үүсвэр	Салбарын үндсэн үзүүлэлтийг бүхий үр нөлөөний үзүүлэлтийг харуулах дашбордад ашиглагдах салбарын мэдээллийн нэгдсэн санг бий болгох ажлыг шат дараатай авч хэрэгжүүлж байна - Мэдээллийн нууцлалыг хангах, мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох аргачлалыг ГБХНХ-ын сайдын 2025 оны А/08 тоот тушаалаар батлууллаа. - Техникийн дэд бүтэц: Дэлхийн банкны төслийн санхүүжилтээр их өгөгдлийн тоног төхөөрөмжийг худалдан авч, Үндэсний дата төв (ҮДТ)-д бүрэн суурилуулж, техникийн орчныг бэлэн болгов. Нийт 5,3 тэрбум төгрөгийн өртөг бүхий 9 төрлийн 59ш тоног төхөөрөмжийг программ хангамжийн хамт ҮДТ-д суурлуулсанаар Ингэснээр салбарын их өгөгдөл болон системүүдийг байршуулах, хэвийн найдвартай ажиллагааг хангахад серверийн хүчин чадал CPU:352 core, RAM:37 TB, Storage:387 TB, -аар тус тус нэмэгдэж байна. - Систем хөгжүүлэлт: Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажилласны үр дүнд	100

						харьяа агентлагуудын 4 мэдээллийн санг нэгтгэсэн "Салбарын их өгөгдлийн сан"-г үүсгэлээ. Үр дүн (Дашбоард): Бодлогын дүн шинжилгээ хийх зориулалттай дараах 5 төрлийн дашбоард хөгжүүлж, ашиглахад бэлэн болоод байна. Үүнд: • Яам 360 KPI • Нийгмийн даатгал (Sigo 360) • Нийгмийн халамж 360 • Хөдөлмөр 360 • Өрхийн мэдээллийн сан 360 • Дээрх нэгдсэн дашбоардуудыг ашиглан нийгмийн даатгал, халамж, хөдөлмөр эрхлэлт, хүн амын чиглэлээр бодлогын дүн шинжилгээ хийх нөхцөл бүрдсэн.	
							83.5

-----oOo-----